

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-39
<i>1.Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	3-39

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны
10 дугаар сарын 17-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 12 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Жаргалмаа, Ц.Мөнх-Оргил, Ц.Туваан;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Сарангэрэл.

Нэг.Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, мөн газрын мэргэжилтэн Ж.Азжаргал, Хууль, эрх зүйн газрын дарга Д.Ренчиндорж, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдорж, мөн яамны мэргэжилтэн Э.Оюун-Эрдэнэ, Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч А.Цолмон, шинжээч Б.Дуламсүрэн, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын дарга Т.Батболд, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Өлзийхутаг, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга Б.Батсайхан, хуулийн зөвлөх, өмгөөлөгч П.Баттулга, Монгол Улсын Боловсролын Их сургуулийн Нийгмийн ажлын арга зүйн тэнхимийн ахлах багш М.Нямдорж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн гэрээт зөвлөх, судлаач С.Энхтуяа, Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны үндэсний хүрээлэнгийн тэргүүн Б.Жавзанхүү, Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээний зохицуулагч П.Цэвээн, Хүүхэд хүчирхийлэхийн эсрэг үндэсний хөдөлгөөний ерөнхий зохицуулагч Д.Ундраа, “Хүйсийн тэгш эрхийн төв” ТББ-ын тэргүүн Г.Ганбаясах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, М.Оюунчимэг, Ц.Идэрбат, Б.Баярсайхан, Ж.Чинбүрэн, Д.Батлут нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын дарга

Т.Батболд, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Өлзийхутаг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, С.Ганбаатар, Ц.Идэрбат, С.Одонтуяа, Б.Бейсен, Ц.Сандаг-Очир, Б.Баярсайхан нар үг хэлэв.

П.Анужин: Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 08 минут үргэлжилж, 17 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 76.5 хувийн ирцтэйгээр 16 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

П.АНУЖИН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
14 цаг 12 минут.

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

П.Анужин: Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 58,8 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын Байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн дагуу дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг танилцуулъя. Балжиннямын Баярсайхан гишүүн ирсэн байна. Батлут гишүүн ирсэн байна. Булгантуяа гишүүн ирсэн байна. Ганбаатар гишүүн ирсэн. Оюунчимэг гишүүн ирсэн байна. Сандаг-Очир гишүүн ирсэн байна. Саранчимэг гишүүн ирсэн байна. Чинзориг гишүүн ирсэн байна. Идэрбат нарын гишүүд хуралдаа хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд ЗГ 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн энэхүү хуулийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлаар өөр саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё. ЗГ 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхийг хийе. Улсын Их Хурлын даргын 159 дүгээр захирамжийн хүрээнд тов дараалал харгалзахгүйгээр чуулганаар

нэн яаралтай горимоор хэлэлцэх шийдвэртэй. Хууль санаачлагчийн илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна.

Түүний өмнө ажлын хэсгийг танхимд хүрэлцэн орж ирэхийг урьж байна. Ажлын хэсгийг ажлын хэсэгт хүрэлцэн ирсэн гишүүдийг та бүхэндээ танилцуулъя. Ажлын хэсгийн гишүүдийг танхимд орж ирэхийг урьж байна. Зулхар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд, Баярмаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Ренчиндорж тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Азжаргал тус яамны Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн. БСШУЯ-наас БШУЯ-наас ажлын хэсгийн гишүүд хүрэлцэн ирсэн байна. Цолмон, Цолмон ирсэн үү? БШУЯ-ны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч, Батсуурийн Дуламсүрэн БШУЯ-ны шинжээч, ЗГ-ын хэрэгжүүлэх агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрынхан ирсэн байна уу? Ирсэн байна. Өлзийхутаг ГБХЗХГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батсайхан Нийслэлийн ГБХЗХГ-ын Хүүхдийн хөгжил хамгааллын хэлтсийн дарга ирсэн үү, ирсэн байна уу? Цахим хөгжил, харилцаа холбооны яам Оюун-Эрдэнэ Цахим хөгжил, харилцаа холбооны яамны мэргэжилтэн, Баттулга хуулийн зөвлөгч зөвлөх, өмгөөлөгч, Харилцаа холбооны зохицуулах хорооноос Батболд ХХЗХ-ны зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын дарга, Нямдорж МУБИС-ийн Нийгмийн ажлын арга зүйн тэнхимийн ахлах багш, ирсэн байна уу? Танилцуулсан хүмүүс босоорой. Сүхбаатарын Энхтуяа НҮБ-ын Хүүхдийн сангийн гэрээт зөвлөх, хүүхэд хамгааллын судлаач. Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай. Хүүхдийн эрх, сургалт судалгааны үндэсний

хүрээлэнгээс Жавзанхүү Хүүхдийн эрхийн сургалт судалгааны үндэсний хүрээлэнгийн тэргүүн, Цэвээн Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээний зохицуулагч, Хүүхэд хүчирхийллийн эсрэг үндэсний хөдөлгөөнөөс төлөөлөл ирсэн байна Даржаагийн Ундраа Хүүхэд хүчирхийллийн эсрэг Үндэсний хөдөлгөөний ерөнхий зохицуулагч, ТББ-ын төлөөллүүд мөн ажлын хэсэгт багтсан байгаа. Гэлэгийн Ганбаясах Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-ын тэргүүн гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Хууль санаачлагч санаачлагчийн илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяад танилцуулна.

Х.Булгантуяа: Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд Хүүхэд хамгааллын тухай хуулийн давхардал хийдлийг арилгах, уг хуулиар хүүхэд хамгааллын үйлчилгээний хувьсах зардлыг батлах эрх, батлах эрх зүйн үндсийг бий болгох, хүүхдийн эрхийг хамгаалахад эцэг, эх, олон нийт, байгууллага, хуулийн этгээдийн үүргийг нарийвчлан тусгах, түүнчлэн хүүхэд хамгаалал гэр бүлийн чиглэлээр ажиллах нийгмийн ажилтныг давтан сургах лицензжүүлэх, үйлчилгээний үр дүнг тооцох эрх зүйн зохицуулалтыг бий болгох замаар хүүхэд хамгаалал хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг илүү нарийвчлан зохицуулах гэж заасныг үндэслэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулахдаа хүүхэд хамгаалал нь бүх нийтийн үйл хэрэг байх зарчимд тулгуурлан Хүүхдийн

эрхийн тухай хуулиар үүрэг хүлээсэн төрийн бүх шатын байгууллага, хүн, хуулийн этгээдийн үүрэг оролцоотой уялдуулж ЗГ хүүхэд хамгааллын байгууллагын удирдлага, зохион байгуулалт, хамгааллын үйлчилгээний хэлбэр кэйс менежмент, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлж, хуулийн давхардал, хийдлийг арилгаж, гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын тогтолцооны эрх зүйн үндсийг бий болгохыг зорилоо. Үүнд 1-д хуулийн үйлчлэх хүрээг Монгол Улсын нутаг дэвсгэрт дэвсгэр дээр түр болон байнга оришин сууж байгаа хүүхэд Монгол Улсын харьяат эсэхээс үл хамааран үйлчлэх, 2-т хүүхэд хамгааллын тогтолцоог өргөжүүлж хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл нутгийн өөрөө удирдах байгууллага бүх шатын Засаг дарга, нийгмийн ажилтан, хамтарсан баг Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны чиг үүрэг, 3-д сум хороонд хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтныг хүүхэд гэр бүлийн удирдлагад ажиллуулах, 4-д Хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн сан, хүүхэд хамгааллын цахим хувийн хэрэг үүсгэж ашиглах.

5-д гэр бүлийн нийгэм, гэр бүл, нийгмийн орчинд хүүхдийг хамгаалах харилцааг өргөжүүлж шинээр хурдан морины уралдаанч хүүхдийг хамгаалах, гамшиг онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгаалал, 6-д хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин, хүүхэд хамгааллын кэйс менежментийн алхам, хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлага, 7-д хүүхэд хамгааллын санхүү үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгож, хүүхэд хамгааллын үйлчилгээний хэлбэр тус бүрээр тусгах зардлыг кэйст тулгуурлан тогтоох. Мөн хуулийн этгээд цалингийн нийт сангийн нэгээс доошгүй хувьтай тэнцэх хөрөнгийн хүү хүүхэд хамгааллын бодлогод төсөвлөх, 8-д хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх

түвшиний үйлчилгээг мэргэжсэн ТББ, олон нийт, сайн дурын ажилтны дэмжлэг туслалцаа, хүүхдийн оролцоотойгоор зохион байгуулж барилга байгууламж, авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд хүүхдийн эрхийн улсын байцаагч, эсвэл хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн төлөөлөл оруулах, 9-д Хүүхдийн эрхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх зүйн байдлыг тодорхой болгож мөн хүүхдийн хөгжлийн үйлчилгээний нэр төрлийг тодорхойлох, хөгжлийн үйлчилгээний аргачлал нормативыг батлах зэрэг нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулаа.

Хууль батлагдсанаар хууль хамгаалах хүүхэд хамгаалах төрийн байгууллагын бүтэц, тогтолцоо, чиг үүрэг бүх түвшинд тодорхойлогдож, анхан шатад сайжирч, хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжлийн түвшинд шаардлагатай хүүхэд бүрд хүргэх боломж бүрдэнэ. Гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын тогтолцоо мөн бэхэжнэ. Хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин, үйл явц, хүүхэд хамгаалалд зориулсан төсвийн үр ашиг өгөөж сайжирч хамгаалал шаардлагатай хүүхэд бүрд чанартай цогц үйлчилгээг үзүүлэх эрх зүйн орчин боловсронгуй болно гэж үзэж байна. Хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулахад 20 гаруй удаагийн хэлэлцүүлэг хийж, ЗГ-ын гишүүд төрийн бүх шатны байгууллага олон улсын болон иргэний нийгмийн байгууллага, их, дээд сургуулийн эрдэмтэн багш судлаачид 1300 гаруй хүүхдийн дунд хэлэлцүүлэг санал авсан. Хуулийн төсөлтэй холбогдуулан хуулийн төслийг дагалдан 14 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэн дэмжиж өгнө үү.

П.Анужин: Булгантуяа сайдад баярлалаа. Хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд холбогдуулж асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Балжиннямын Баярсайхан гишүүнээр нэрсийг тасалъя. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: 1-д сая сайдын танилцуулгыг сонслоо. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл өөрөө хууль тогтоомжийн хуулиа хэр яаж дагаж мөрдөж явж байгаа юм бэ? Саяын л нэг хүүхдийн асуудал гарснаас хойш гэв гэнэтхэн сэрсэн юм шиг бүгдээрээ ингээд хүүхэд хамгаалал руу асуудал ороод ирчихсэн. Тэгээд сая танилцуулгадаа хэдэн мянган хүүхдээс санал юу санал авсан гэнэ вэ, хэзээд нь ингээд санал авчихсан юм бэ? Энэ хууль чинь ер нь хэзээ өргөн баригдаад явж байсан юм бэ, энэ хүүхэдтэй холбоотой чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын, төрийн төрийн бус байгууллагуудын саналыг яаж авсан юм, энэ хуульд хэрхэн яаж тусгаж байгаа юм бэ гэдгийг нэгд тодруулж асууя.

2-т энэ 7, 8 төрлийн өөрчлөлтүүдийг хийхээр яаж байгаа юм байна. Ер нь энэ хариуцлагын асуудлыг шинэчилсэн найруулгаар яаж хөндөж гаргаж ирж байгаа юм бэ? Хүүхдээ сургууль, цэцэрлэгт найддаг, багш нарт найддаг, ингээд цаашаа яваад байх уу? Хүүхдээ хаана явж байгааг мэдэхгүй, хүүхдээ хэнтэй нөхөрлөж байгааг мэдэхгүй, юу санаж бодож байгааг нь мэдэхгүй, үзэл бодлыг нь хуваалцдаггүй, амьдрах суралцах орчин нөхцөлийг нь бодитойгоор бүрдүүлж өгөөгүй ийм эцэг, эхчүүдэд цаашидаа ер нь хариуцлагын асуудлыг би энэ хуулийн төслийн уншлаа л даа. Яаж яг хариуцлагыг нэмэгдүүлж байгаа юм бэ,

чангаруулж байгаа юм бэ? Тэгээд тэр хүүхэд яг хэний хүүхэд юм бэ? Эхний ээлжид тэр хүүхдийг асран хамгаалах, өсгөж хүмүүжүүлэх, харж хандах нь хэний үүрэг вэ? Тэгээд өөрийнхөө хүүхдийг эцэг, эхчүүд нь төрсөн эцэг, эхчүүд нь байсаар байж ингээд өөрсдийн хараа асрамж дутсанаас болж, хүүхэдтэйгээ тулж ажиллаагүйгээс болж эрсдэлд оруулчихаад, дараа нь төрлүү чихдэг ийм байдлаа үргэлжлээд явах юм уу яах юм бэ? Энэ дээр энэ шинэ хуулийн төсөл дээр эцэг, эхчүүдийн энэ үүрэг хариуцлагыг хэрхэн яаж сайжруулж, чангаруулж байгаа юм, хуульд яаж өөрчлөлт оруулах гэж байгаа юм гэдгийг 2-т асууя.

Дагасан хуулиар 14, 5 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар оруулж ирж байгаа юм байна. Тэр хамгийн сүүлд байгаа тэр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн тэр 2.1 заалт яг ямар учир утгатай юм бэ? Юунд хамаатай заалт юм бэ энийг тодруулж өгөөч гэсэн. Эхний ээлжид нэг ийм 3 асуултад хариулж өгөөч.

П.Анужин: Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Булгантуяа сайд хариулт өгье.

Х.Булгантуяа: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийг 2021 онд энэ хуулийг боловсруулахаар ерөнхийдөө ажлын хэсэг гарч ажиллаж байсан. 2021 онд АНУ-ын Төрийн департаментаас world vision-той хамтран хүүхэд хамгааллын зураглалыг бас хийсэн байсан. Бид өнөөдөр та бүхэнд бас энэ тайланг хүргүүлж байгаа. Мөн НҮБ-ын хүүхдийн сангаас Хүүхэд хамгааллын тухай 2016 онд анх батлагдсан энэ хууль дээр бас үнэлэлт дүгнэлт хийсэн байдаг. Эдгээр хуулиуд дээр гаргасан үнэлэлт дүгнэлтийг үндэслэн бид энэ хуулийг боловсруулаад өнгөрсөн хавар 6 сард ЗГ-ын хурлаар бас нэг хэлэлцсэн юм. Тэгээд

яах вэ намар бид нар өргөн барья. Хавар чуулган тарахаас өмнө арай хэлэлцээж амжихгүй байхаар байна 1 дүгээрт. 2 дугаарт бас өргөн барихаасаа өмнө өргөн барьсны дараа ч гэсэндээ олон нийтийн хэлэлцүүлгийн дунд байж энэ хүүхэд хамгааллын асуудал ганцхан төр засгийн асуудал биш эцэг эх, олон нийт, цахим хүүхдүүд ч гэсэн бие биеийгээ хамгаалдаг хайрладаг бас ийм сэтгэхүйг тогтолцоог бий болгоход бид нар энэ Хүүхэд хамгааллын хуулийн хэлэлцүүлгийг нэлээн өргөн дэлгэр явуулж батлуулах нь зүйтэй юм байна гэж үзэж, хаврын чуулганаар өргөн барихгүйгээр сая намрын чуулганаар өргөн барьж байгаа.

Ер нь бол яах вэ хууль бол бэлтгэгдчихсэн байсан, олон энэ төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагууд, зөвлөхүүд бас оролцож энэ хууль дээр ажиллаж өргөн юу өргөн барьж байгаа юм. Хариуцлага дээр Баярмаа дарга нэмчих үү?

П.Анужин: 2, 3 дугаар асуулт дээр мөн 1 дүгээр асуулт дээр Баярмаа дарга нэмэлт хариулт өгөөд асуултад гүйцээж хариулъя. 1 номерын микрофон нээе.

Н.Баярмаа: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу НҮБ-ын хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Английн хуулийн фирмтэй Монголын IRIM судалгааны хүрээлэнтэй хамтарч бас хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын судалгаа хийсэн. Сая Булгантуяа сайдын хэлсний дагуу бол яг тогтолцоо маань ажиллаж байна уу, ямар хуулийн өөрчлөлт хийх ёстой вэ гэдэг асуудал дээр бас үнэлгээ судалгаа хийгдсэн. Тэгээд энэ үнэлгээ судалгааны хүрэн дээр 21 оны 9 сард үзэл баримтлал батлагдсан. Тэгээд энэнээс хойш хүүхдийн чиглэлээр ажилладаг ТББ, иргэний нийгмийн байгууллага, өөрийн салбарын албан хаагчдад 2 удаа хүүхдийн оролцооны үндэсний чуулган хийж, нийт

оролцогч 600 гаруй хүүхдүүдээр хэлэлцүүлж бас санал авч, процессын дагуу явсан байгаа.

Гэр бүл дэх хүүхэд хамгааллын асуудал гээд эцэг эхийн үүрэг хариуцлагын асуудал өмнө нь 3, 4 заалттай байгаа. Тэгээд энэ дээрээ бид нар бас нэмээд эцэг, эхчүүд нийгмийн халамжийн тэтгэмж авахын тулд хүүхдийн эерэг аргаар хүмүүжүүлэх, хүүхдийн эрх хамгааллын талаар сургалтаа авдаг байх ийм нөхцөлд мөнгөн тэтгэмжийн зохицуулалтын асуудлыг оруулсан. Хүүхэдтэй холбоотой эрх мэдлээ урвуулан ашиглах, зүй бус харьцахыг, бие махбодын шийтгэл хэрэглэхийг хориглох ийм заалтыг оруулсан. Хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хүүхдээр хөдөлмөр эрхлүүлэх асуудлыг хориглох ийм заалтыг оруулсан.

П.Анужин: Микрофоноо ойрхон байлгая.

Н.Баярмаа: Хүүхдүүдийн нэр төрд сөргөөр нөлөөлөх цахим дүрс ашиглах, гэрэл зургаар дамжуулах, цахим орчинд байршуулах энэ асуудлуудыг бас нэмэлтээр оруулсан байгаа. Хариуцлагын асуудалд бол Зөрчлийн тухай хуулийн дагуу 6.20-д эцэг эхийн үүрэг хариуцлага яг энэ асуудлууд бол яг 300 мянга хүртэлх төгрөгөөр торгох асуудлууд байгаа. Тэгээд хүүхдийн эрхийн энэ зөрчлийн асуудалд хариуцлага тооцож ажилладаг хүүхдийн эрхийн улсын байцаагчид ажиллаж байгаа. Тэгээд энэ улсын байцаагчдын зөрчил хянан шийдвэрлэсэн энэ тохиолдлуудын 76 хувь нь яг эцэг эхийн энэ үүрэг хариуцлагатай холбогдолтой, хүүхдийн эрхийн зөрчлийн хариуцлагуудыг тооцуулаад явж байгаа. Мөн гэмт хэргийн шинжтэй бие махбодын хүчирхийлэл бэлгийн хүчирхийлэл хэрэглэсэн тохиолдолд бол Эрүүгийн хуулиараа хариуцлагын асуудал бас давхар явж байгаа. Тэгээд ЗГ-аас боловсруулж байгаа Гэр бүлийн хуультай бид нар бас яг эцэг эхийн үүрэг

хариуцлагын асуудлыг бол яг нэг бүрчлэн тулгаж бас зохилцуулж юу яаж зохицуулж бас оруулж ирсэн.

3 дахь асуултад бол төрийн өмчийн хуулийн орон нутгийн худалдан авалтын ажиллагааны тухай хууль байгаа. Тэгээд энд бол энэ хуулийн нэг шинэ оруулж ирсэн асуудал Хөдөлмөрийн хуулийн 43.3-д заасан хүүхэд хамгааллын бодлогыг байгууллага салбар ААН хэрэгжүүлэх асуудал байгаа. Тэгээд энэ дээр уялдуулаад бас төрийн өмчөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авч байгаа байгууллагууд нөгөө хүүхэд хамгааллын бодлоготой байх, хүүхэд хамгааллын бодлогогүй байх юм бол оролцохгүй гэсэн ийм заалтыг л бид нар ААН, бизнес эрхлэгчдээ нөгөө ийм хүүхдэд ээлтэй бодлого, энэ Хөдөлмөрийн хуулийн 43.3-ыг хэрэгжүүлэх нөгөө зохицуулалт болох үүднээс ингэж тусгайлан бас оруулсан байгаа.

П.Анужин: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

М.Оюунчимэг: Сая ярьж байгаатай бас санал нэг байна л даа. 2024 оны төсөв төсвийн төсөл өргөн барьсны дараа сэтгэл сэртхийлгэсэн кэйс гарсны дараа ингээд хуулиа шинэчилсэн найруулгаар оруулж ирж байна. Энэтэй холбоотой төсөв мөнгөний асуудлууд бас яригдана. Ямар ч байсан яах вэ тэгээд нөгөө эмэгтэй гишүүдийн өргөн барьсан хуультай хамтатгаад хэлэлцээд явъя гээд салбарын яам маань шинэчилсэн найруулгаар хуулийн төслөө оруулж ирж байна. Энэтэй давхцаад бас нөгөө Гэр бүлийн хууль Хууль зүй, дотоод хэргийн яам маань өргөн бариад ингээд 3 хууль 3 ч яах вэ ингээд 2 хууль маань явж байна. Тэгээд цогцоор нь шийдэх л гол нь бидний зорилго байгаа. Тэгээд би ингээд нэг бүрчлэн хуулийн шинэчилсэн найруулгыг уншсан. Яах вэ тэр үе тэнгийн дээрэлхэлт гэр бүл, зөрчлийн хохирогч, асралт гэр бүл гэдэг юм уу орчин үеийн

бас нэг тулгарч байгаа зарим нэг шинэчлэлийн асуудлууд бол дотор нь орсон байна лээ. Энэ бол маш зөв.

Харин 2 зүйл дээр би бас ингээд тодорхойгүй юмнууд байна. Баярмаа дарга ч мэдэж байгаа энд салбарын бүх хүмүүс сууж байна. Сая чуулганаар хэлэлцүүлэг явсны дараа над руу бас салбарын яг тэр нөгөө нэг халуун цэг дээр нь ажилладаг хүмүүс энийг энэ хуулийг яах вэ заалтыг зарим нэг байдлаар чангалж өөрчилсөн байна. Хэрэгжүүлэх нь хүмүүс. Тэгэхээр тэд нар маань яг энэ нөгөө нэг хүний нөөц бүтцийн асуудал нэг өрхөд хүүхэд хамгаалагч тэд оногдоно гээд бүүр хуульчлаад өгөхгүй бол 20 мянган өрхөд ганцхан хүүхдийн эрхийн байцаагч юм уу, нийгмийн ажилтан энэ тэр гээд л ганц жишээ нь ЧД-ээр жишээ авахад ийм байгаа байхгүй юу. Одоо бид нар нэгэнт энэ ажлыг хүүхэд хамгааллын ажлыг цогцоор нь шийдье гэвэл ганц хууль гаргаад юм бүтэхгүй гэдгийг нь бид нарын өмнө гаргасан хуулиуд харуулаад байгаа. Тэгээд энэ нөгөө салбар дундын хамтын ажиллагаа. Энийг хэн хэрэгжүүлэх вэ хүн хэрэгжүүлнэ. Тэгэхээр энэ шинэчилсэн найруулгын хууль энэ нөхцөл байдлаа дагаад төсөв хэлэлцэж байгаа энэ үед бүгдээрээ хүний нөөцөө нэмчихье л дээ. Хүүхдийн эрхийн байцаагчийн орон тоогоо бүүр бараг хуульчлаад өгчихвөл яасан юм бэ? Хүн амаар нь тэдэн хүн амтай бол нэг өрхөд тэдэн хүүхдийн эрхийн байцаагч байна гээд хуульчлаад өгчихөөд, энийг тухайн аймгийн, дүүргийн Засаг дарга дагаж заавал мөрдөнө гээд хуульчлаад өгчихвөл энэ чинь хэрэгжээд яваад, жинхэнэ хүүхэд хамгааллын кэйс бодит ажил болох юм шиг санагдаад байх юм.

Доод талаас нь бас яг тэгж яриад бид нарт хүсэлт ирүүлээд байна шүү дээ. Үгүй ээ гишүүд та нар уг нь их чухал юм яриад л байсан. Тэгээд л эцэстээ нэг яг тэр хүний нөөцтэй холбоотой, бүтэц зохион байгуулалттай холбоотой салбар дундын хамтын ажиллагаатай холбоотой нь хуульд яг тодорхой нарийн

тусгагдаагүй орж ирж байгаа байхгүй юу. Энд яах вэ нөгөө гэр бүлийн яг энд нь байж л байна л даа. 4.15 дээр гээд л тайлбарлах байх. Нөгөө хүүхэд хамгааллын баг ингэж ажиллана баг ингэнэ гээд байдаг. Гэтэл өнөөдөр багт хэдэн хүн байгаа билээ гэдгийг бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Тэгэхээр энэ асуудлыг жишээ нь хуульд яаж шийдэх гэж оруулж ирж байгаа вэ 1 дүгээрт.

2 дугаарт бид нар өнгөрсөн 16-аас 20 онд маш том дэвшил сая энэ хүүхдийн хамгааллын тухай асуудал хөндөгдөхөд ганц гийх мэдээ нь хүүхэд хамгааллын төсвийг 340 хэдхэн сая байхад 8 тэрбум дээр авчирсан төсвийн ажлын хэсгийг хүртэл ахлаад явж байсан гээд би хэлж байсан. Тэгээд энэ бол боломжийн гэж байгаа. Гэхдээ энийг 14 тэрбум болгохоор оруулж ирж байгаа гэж байгаа. Тэгээд би бас Булгантуяа сайдыг одоо яг та энэ нөгөө нэг хүүхэд хамгааллын төсвийг маш тодорхой болгож ингэж зааж өгөх хэрэгтэй байна. Энэ нь яг хүүхэд хамгаалалд буюу хамтарсан баг тэдэн хувь нь тусгагдана. Аймаг, дүүрэг, сумын хүүхэд хамгааллын багт тэд нь ингэж явах явна. Тэгвэл бид нар эргээд нөгөө ажлын үр дүнг нь тооцоход их хэрэгтэй байгаад байна. Гэтэл өнөөдөр тэр дүүрэг дээр, тэр хороон дээр тэр сум яг хамтарсан баг дээр санхүүжилт нь бараг очихгүй, кофегоо өөрсдөө аваад, автобусандаа өөрсдөө мөнгөө төлөөд явж байна. Тэгээд ийм болохоор тэнд ажиллах хүн олдохгүй жсоохон хугацаанд ажиллачхаад л гараад явчих юм гээд. Та ч бас чуулган дээр ингээд дурдаж байсан.

Тэгэхээр энэ төсвийн задаргааг бас энэ тодорхой хэмжээгээр хуульчлаад өгчих ч юм уу эсвэл тийм бололцоо нь байна уу? Ер нь төсвөө яаж задаргаагаар хэдийг нь яаж хүүхэд хамгаалалд явах вэ, хэдийн юунд зарцуулах вэ гэсэн тийм задаргаа.../минут дуусав/

П.Анужин: Оюунчимэг гишүүний асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Булгантуяа хариулна.

Х.Булгантуяа: Оюунчимэг гишүүний асууж байгаа, тавьж байгаа санал бол маш зөв. Үнэнийг хэлэхэд ямар ч ажлыг мянган техник тоног төхөөрөмж хөгжлөө гээд хамгийн мундаг компанийн амжилтын 70 хувь нь хүн л байдаг гэдэг. Тэгэхээр энэ хүүхэд хамгаалал гэдэг бол тэр чигээрээ хүний ажил. Нэг техник тоног төхөөрөмж хийхээсээ илүүтэйгээр. Анх 2016 онд 300 гаруй сая төгрөгийн төсөвтэйгөөр зөвхөн агентлагийн хэдэн ажилтан эхэлж байсан бол өнөөдөр 21 аймагт 9 дүүрэгт нийтдээ түр хамгаалах цэг байрууд, дээрээс нь нэмээд нэг цэгийн үйлчилгээний төвүүд гээд 30 орчим байруудаар хүүхэд хамгааллын үйл ажиллагааг явуулдаг. 21 аймаг 9 дүүрэгт бид нар салбартай. Хүүхэд хамгааллын чиглэлийн манай дүүргүүд дээр гэж байхад нийтдээ 6-аас 8 орон тоотойгоор ажилладаг. Үнэнийг хэлэхэд бол 6-аас 8 орон тоон дээр нь зарлаад, зарлаад манай том дүүргүүд гэж байхад 6 орон тооноос 3 хүнтэй, 8 орон тооноос 4 хүнтэй л ажиллаж байгаа. Сая 7 сарын 1-нээс цалин нь арай нэг нэмэгдээд 1 сая төгрөгт хүрсэн. Тэрнээс өмнө бол 700 орчим төгрөгийн цалинтай явсан.

Хэдийгээр энэ ажил мэдээж хүүхдэд сэтгэлгүй хүн бол энэ ажлыг хийхэд их хэцүү ажил. Хүний амьдралын сая бид хэд Дорноговьд болсон кэйс дээр Монголчууд бүгдээрээ л бид нар ямар их цочирдсон, тэгэхэд энэ хүмүүс бол ийм кэйстэй бараг л өдөр тутамд нүүр тулж ажилладаг хүмүүс. Тэгэхээр ажлын ачааллыг бас зохистой байлгахгүй бол энэ салбарын ажилтнуудын 50 гаруй хувь нь 1-ээс 2 жил ажиллаад гарчхаж байгаа. Энэ хуулийг дагуулаад 1 дүгээрт хороо болгон дээр мөн агентлаг маань сумд ерөөсөө хариуцсан хүүхэд хамгааллын гэдэг хүн байдаггүй. Тэгэхээр сум болгон дээр хүүхэд хамгааллын 1 дүгээрт нийгмийн ажилтантай болно

гэж оруулж өгсөн байж байгаа. Одоо бол нийгмийн ажилчид маань хороо дээр байгаа нийгмийн ажилтнууд нь бол орон нутгаас санхүүждэг, бүхий л асуудал хариуцдаг соёл, спорт, урлаг, мод тарьсан тайлан, дээрээс нь нэмээд юу юу ч гэлээ нийтдээ нэг нийгмийн ажилтан бараг 300 орчим тайлан гаргадаг. Хүүхэд хамгааллын асуудал бол энэ хүний хариуцдаг 300 тайлангийн нэг л тайлан байгаа. Хүүхдийн асуудал бол.

Тэгэхээр нэгэнт өнөөдөр Монголын хүн амын 1/3-ийг эзлээд байгаа хүүхдийн асуудал ийм хурцадмал байгаа цаг үед та 300 тайлангийнхаа хажуугаар гаргахынхаа хажуугаар хүүхдийн асуудлыг хариуцаарай гэхэд бол их хэцүү. Дээрээс нь нэмээд нийслэл Улаанбаатар хотын зарим хороод дээр бол хүн ам маш ихтэй бараг 20 мянга орчим хүн амтай. Тэгэхээр үүнийгээ дагаад нэг хүн дээр ирж байгаа ачааллын тоо өндөр байгаа учраас бид хуулийг дагаад хороо болгон дээрээс нь нэмээд орон нутагт сум болгон орон тоотой болно. Хүүхдийн байцаагч гэхэд ч улсын хэмжээнд 40 хэдэн хүүхдийн байцаагчтай, аймаг жишээлбэл зарим аймгууд бол ганцхан хүүхдийн байцаагчтай, цөөхөн аймаг 2 хүүхдийн байцаагчтай. Тэгэхээр хүүхдийн улсын байцаагчгүй байна гэхээр энэ нөгөө хүүхдүүдийн асуудлыг мэргэжлийн хяналтын байцаагч болох хүүхдийн байцаагч болохоос амархан болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хүүхдийн байцаагчийн орон тоог бид нар энэ хууль батлагдсанаар ЗГ 1 дүгээрт хүн амынхаа тоотой, 2 дугаарт хүүхдийн эсрэг гараад байгаа кэйсийнх нь тоотой уялдуулж ЗГ 3 жил тутамд аймаг орон нутгуудыг квотоор баталж өгдөг байя гэж байгаа юм. Зарим аймгуудын хувьд өөрсдийнх нь хүн ам нь хэдийгээр цөөхөн ч гэсэндээ хөл хөдөлгөөн ихтэй зах худалдааны төвүүд ихтэй ч гэдэг юм уу. Жишээлбэл дор Дорноговь аймаг, Өмнөговь аймгийн хувьд гэхэд газар нутаг ихтэй өөрсдийнх нь хүн ам бага ч

гэсэндээ хөл хөдөлгөөн ихтэй учраас ийм гэмт хэргийн тоо бас өндөр байх гээд байдаг магадлалтай. Тэгэхээр ийм тохиолдолд аймаг орон нутгаас бид нар ЗГ-аас санхүүжүүлж, хүүхдийн орон тоог нэмэхээр шийдвэрлэсэн байж байгаа.

Хүүхдийн энэ байгууллагын төсөв бол 2020 оноос хойш нэмэгдээгүй. 20 онд 8 тэрбум анх 2016 онд эхлээд л 27 онд 900 сая болсон, 2018 онд 6,4 тэрбум, 2019 онд 7,6 тэрбум байгаад сүүлийн 20, 21, 22, 23 онд 4 жил 8 тэрбум төгрөгөөр байгаа. Аймаг орон нутгууд жишээлбэл түр хамгаалах байр нэг цэгийн үйлчилгээ дээр дэмжлэг үзүүлж хамтарч ажилладаг орон нутгууд байна, тэгж чаддаггүй орон нутгууд ч байна. Хүүхэд хамгааллын энэ асуудал бол энэ босоо тогтолцоотой бүтэц. Энүүнийг.../минут дуусав/

П.Анужин: Булгантуяа сайд асуултад гүйцээгээд хариулъя. Хуульд хэрхэн тусгагдсан талаар, тусгаж болох эсэх, одоо туссан юм уу тусаагүй юм уу, ямар бодлоготой юм тодорхой хариул. Хуультайгаа уяж хариулт өгье.

Х.Булгантуяа: Санхүүжилтийн хувьд бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Сангийн сайд 2 хамтарсан энэ нөгөө санхүүжилтийнх нь журмыг баталдаг байж байгаа. Сая бид нар энэ төсвийг өргөн барихаасаа өмнө манайхаас Сангийн яамтай нэлээдгүй сууж байж кэйс болгон дээр ажиллах зардал, бид нар кэйс үүсгээд явлаа гэхэд үүний дараа нөхөн сэргээх үйлчилгээ эмчилгээ гээд ингээд нэлээдгүй урт хугацаа ордог. Тэгээд энэ болгон дээр дунджаар нэг хүүхдэд зарцуулж байгаа төсөв, санхүүжилт хугацааг нь тооцоолоод хамтарсан байдлаар батлахаар хууль дээр тусгаж өгсөн байгаа.

П.Анужин: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулга авъя.

М.Оюунчимэг: Тэгэхээр яг зарцуулалт нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд 2 энэ журмаар тухай бүрд нь зохицуулаад явна гэж ойлгогдохоор бол сая хэллээ тийм үү? Ер нь энэ нөгөө нэг төсөвтэй холбоотой юман дээр яагаад энийг асуугаад байна гэхээр жишээлбэл би Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга байхдаа ХЭҮК аудит 2-оор дүгнэлт хийлгэсэн чинь ялангуяа аймаг сумдад хүүхдийг хамгаалахад төсөвлөсөн мөнгийг өвс худалдаад авчихсан ч гэдэг юм уу эсвэл өөр юманд зарцуулчихсан тэс хөндлөн юмнууд зарцуулсан бараг ихэнх аймагт гарсан. Тэгээд сая тэр хүүхдийн эрхийн байцаагчийн тухай та өөрөө бас хэлж байна. Тэгэхээр энэ дээр бид нар яг хуульчилж өгмөөр байна. Тэр төсвийг зарцуулаагүй бол ямар хариуцлага үүрэх юм бэ гээд 1-д.

2-т нь эмэгтэй гишүүд санаачлаад Ерөнхий сайд маань бүүр дэмжээд нөгөө камержуулалтын асуудлыг цогцоор шийдье гэсэн энэ төсөв дээрээ суугаад цогцоор шийдэхээр орж ирж байгаа бол ЗГ-ын хуралдаан дээр энэ ямархуу байдлаар яригдсан бол ийм асуулт байна.

П.Анужин: Сайд Булгантуяа хариулъя.

Х.Булгантуяа: Камержуулалтын хувьд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу торгууль энэ юунаас орсон орлогын 40 орчим хувийг орон нутаг авдаг, үүнийг камержуулалт гэрэлтүүлэг зэрэг энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулахаар хуульчилсан байдаг. Энэ хүрээнд яг энэ бол Хүүхэд хамгааллын тухай хууль дээр биш энэ дэд бүтцийг ер нь бол Засаг захиргаа нэгжийн тухай хуулиас авхуулаад энэ тохижилтын ажлууд бол яг аймаг орон нутгуудад ерөнхийдөө шийдээд явахаар хуульчилсан байгаа. Саяхан баталсан Засаг захиргаа нэгжийн тухай хуулиар ч гэсэндээ бас

тийм. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор энэ бол одоогоор манай энэ хууль дээр бол шууд камержуулалтынхыг бол энэ хуулиар санхүүжүүлэхээр бол байхгүй байгаа. Бид нар бол хүүхэд хамгааллын хамтарсан багаа ч тэр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Засаг дарга ахалдаг зөвлөлөөс ч гэсэн тэр. Ер нь энэ хүүхэд хамгаалалттай холбоотойгоор хүүхдийн хамгийн их тоглодог, ирж очдог газрууд дээр үнэлгээ хийдэг, тэр үнэлгээний тайланг аймаг орон нутгуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл дээр танилцуулдаг. Хамтарсан баг дээр энэ тэр танилцуулдаг. Заримдаа харамсалтай нь энэний санхүүжилт нь.../минут дуусав/

П.Анужин: Эхний асуултад микрофон дээр Булгантуяа сайд хариулъя. Хүүхэд хамгаалалд зарцуулагдах ёстой төсвийг тэр өвс элдэв юм дээр зарцуулчихсан байдаг аудит хийлгэхэд гээд. Тэгэхээр энэ хууль дээр яаж хянахаар зохицуулагдсан байгаа вэ гэдэг асуултад нэг номерын микрофонд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам хариулъя.

Н.Баярмаа: Хуулийн төслийн 6 дугаар бүлэг хүүхэд хамгааллын санхүүжилт, хяналтын асуудал байгаа. Санхүүжилтийн эх үүсвэрүүдийг нь зааж өгсөн. Улсын төсөв болон орон нутгийн төсөв үндэсний болон олон улсын төсөл хөтөлбөр, тэгээд хуулийн этгээдийн хандив тусламж. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн үйлчилгээний төрөл кэйсийн хэлбэрээр улс болон орон нутгийн төсөвт тусгаж хэрэгжүүлнэ гээд. Хүүхэд, гэр бүлийнхээ кэйс болон хүн амын эрсдэлт нөхцөлд. Хяналтын асуудлыг бүх шатны байгууллагаас авхуулаад төрийн захиргааны төв байгууллага, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага, иргэдийн хурал, үндэсний зөвлөл, нутгийн өөрөө удирдах байгууллагууд хяналт тавих асуудал байгаа. Тэгээд дээрээс нь нэмээд мэргэжлийн байгууллагуудаар хөндлөнгийн хяналтыг хийх асуудлыг бас

давхар оруулж ирсэн байгаа. Хөндлөнгийн хяналттай байх.

П.Анужин: Асуултад тодорхой хариулахгүй байна, Баярмаа даргаа боловсруулсан хууль чинь уул нь сайн төсөл орж ирсэн, аятайхан ажлаа мэддэг хүн шиг хариулт өгмөөр байна. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууя. Асуултад тодорхой хариулъя.

М.Оюунчимэг: Сая Баярмаа даргын хэлээд байгаа тэр хөндлөнгийн хяналт аудит хийлгээ эд нар чинь угаасаа энэ хуулиудаар хэрэгжээд явж байгаа, бүх хуулийн заалтад байгаа. Гэхдээ энэ амьдралд хэрэгжихгүй та бид нарын хийлгэсэн тэр би хэлээд байна шүү дээ. Хүний эрх аудитын дүгнэлтүүдээр хүүхэд хамгааллын төсөв гэдгийг ер нь тоодог ч үгүй аймаг сумдад тэрийг өөр юманд зарцуулаад явчихдаг, дараа нь ямар ч хариуцлага тооцдоггүй. Үнэхээр өөр юманд энд зарцуулжээ гээд гараад ирээд тэрний дагуу мөрөөр юу хийв гэхэд бас байхгүй. Тэгэхээр би энэ хууль дээр хэрвээ хүүхэд хамгааллын төсвийг өөр юманд зарцуулсан бол ийм хариуцлага хүлээнэ гээд бүүр тийм заалт оруулаад өгчихвөл яасан юм бэ? Тэгээд саяын таны хэлдэг тэр хяналтын механизмууд угаасаа л үйлчилж ирсэн хуулиудад байгаа байхгүй юу одоо, бүгд байгаа.

Тийм учраас бид нар хийлгээд байна. Гэхдээ энэ чинь амьдралд хэрэгжихгүй хүүхэд хамгааллын мөнгө зориулалтын юмандаа явахгүй байгаад байна гэж хэлээд байхад та ингээд юу хариулаад байх юм, тодорхойгүй байгаа хуулийг хариулаад. Одоо тэгвэл энийг бүгдээрээ хэлэлцэж байгаад тусгая л даа, төсвийн тэдэн хувь нь байна гээд заагаад өгье л дөө.

П.Анужин: Булгантуяа сайд тодорхой хариулт өгье.

Х.Булгантуяа: Энэ хуулийн 7 дугаар бүлэг дээр 7.2 дугаар зүйл дээр

хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага гэж байгаа. 1 дүгээр энэ хуулийг зөрчсөн бол албан тушаалтны хувьд гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага, мэдээж энэ бол төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн салбарын сайд тэгээд доошоо хариуцсан хэлтсийн дарга, газрын дарга нар Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээдэг байгаа. 2 дахь нь энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээд нь хэрвээ эрүүгийн шинж чанартай бол Эрүүгийн хууль эсвэл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэхээр заасан байж байгаа. Тэгэхээр бусад хуулиудаар нөгөө Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн хууль, дээрээс нь нэмээд Аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль гээд бусад хуулиудаар санхүүд нь байгаа учраас энэ эдгээр албан тушаалтнууд бол төрийн албан хаагчид учраас энэ хуулийн дагуу хариуцлагыг хүлээнэ гэж оруулж өгсөн байж байгаа.

П.Анужин: Булгантуяа сайдын хариулт бол өмнө нь одоо хэрэгжиж байгаа хууль нь ч гэсэн энэ заалт тодорхой тусгагдсан байдаг боловч энэ хуулийн заалт хэрэгждэггүй тухай. Тэгэхээр хэрхэн хэрэгжүүлэх юм бэ энэ хууль дээр яаж илүү нарийвчилж чангатгаж оруулж ирсэн юм бэ гэдгийг Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн маш тодорхой асуусан боловч бас хариулт хангалтгүй байлаа. Цаашидаа та нар маань бас энэ дээрээ анхаарна биз. Асуулт асуух гишүүдийн нэрсийн дараалалд Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүнийг оруулаад өгөөрэй. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг бас нэлээн сайн уншиж танилцлаа. Тэгээд энэ дээр яах вэ хүүхэд хамгаалал дээр гардаг хүндрэлүүдийн асуудлаар би орон чуулганы нэгдсэн хуралдаан дээр ч

бас нэлээн бас тодорхой тайлбарлахыг хичээсэн. Тэгээд энэ та бүхний танилцуулсан энэ зүйл дээр энэ 2021 онд Монгол Улс НҮБ-ын Хүүхдийн сангаас Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ гэсэн ийм зүйл гаргасан юм байна л даа. Тэгээд энэ бол яг нөгөө миний хэлж байсан зүйлүүд бол энэ дээр би тусгагдчихсан байгаа юм байна гэж ингэж харж байна. Тэгэхээр та бүхэн энийг бас харчихсан байх. Тэгэхээр яг энэ шинэчилсэн найруулга дээр энэ НҮБ-ын хүүхдийн сангаас гаргаад ирсэн энэ хуулийн цоорхой эндээ байна гээд ингээд тод томруун заагаад өгчихсөн зүйл энэ шинэчилсэн хуулийн найруулга дээр яаж туссан бэ? Жишээ нь энэ дээр санхүүжилт хяналтгүй, санхүүжүүлээгүй хүүхэд хамгааллын үйлчилгээ хамтарсан багийн үйлчилгээнд зардал хуваарилдаггүй байгаа энэ тэр нь бол бас хүүхэд хамгааллын энэ үйл ажиллагаа тасалдахад хүрсэн байна гэсэн товчхондоо ийм дүгнэлт байна шүү дээ бас. Тэгэхээр яг энэ шинэчилсэн хуулийн найруулга дээр энэ кэйс дээр гараад байдаг ийм зүйлүүдээ ер нь яаж тусгасан бэ гээд 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт хүүхдийн хүчирхийллийн асуудал гэр бүлийн хүрээнд 77 хувьтай үйлдэгддэг байна. Энэ бол өндөр хувь. Өнгөрсөн хугацаанд энэ 77 хувь үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн энэ асуудал дээр тухайн хүүхдийг асарч хамгаалах ёстой эцэг эх хариуцлага тооцогдсон тийм жишээ кэйсүүд байна уу? Бид нэг эрэгнээс унаад ирчихсэн юм шиг л хүүхдийн асуудал яриад байгаа. Тэр чинь эцэг эхтэй, эцэг эх чинь тодорхой үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлээгүйгээс болоод хүүхэд хүчирхийлэлд өртсөн, эрсдэлд орсон ийм тохиолдлуудад эцэг эхэд нь хариуцлага тооцсон ийм кэйс улсын хэмжээнд ер нь байдаг уу?

3 дугаарт энэ хуулийн төсөл дээр нөгөө нийгмийн ажилтан гээд сая гишүүдийн яриад байгаа энэ зүйлийг бас оруулж ирсэн байна л даа. Энэ дээр сум,

хороо гэж 2 үг оруулчихсан байна сум, хороо. Тэгэхээр өнгөрсөн хугацааны энэ олон айхтар кэйсүүдийн гарч байгаа давтамж нь энэ засаг захиргааны нэгжийн хуваариар нь авч үзвэл яг хаана байгаа вэ? Сум гэдгийг та нар 330 сумыг нийтэд нь авч үзэж байна уу? Гэтэл тэр дотор чинь хүн амын тоо, нөгөө багийн иргэдийн тоо энэ бүх зүйлүүд чинь харилцан адилгүйгээс болоод зарим нь 500 хүнтэй багийн дарга байхад зарим нь 7000 хүнтэй багийн дарга байж байгаа. Тэгэхээр сум болгонд нийгмийн ажилтан нэмнэ гэж ингэж байгаа чинь 330 сумд нэмэхээр аймгийн төвийн сум дээр нэг л хүн болж хувирах гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр яг иймэрхүү байдлаар юмныхаа жоохон углуурга руу ороод аймгийн төвийн сум дээр нэг хүн нэмээд нэмсэн ч яалаа байсан ч яалаа шүү. Ер нь яг үнэндээ бол. Би бол багийн түвшинд аймгийн төвийн сум дээр багийн түвшинд, 6000-аас дээш хүн амтай бол багийн түвшинд ч гэдэг юм уу ингээд оруулаад ирвэл би бол арай илүү амьдралтай болох болов уу. Тэгэхээр сум, хороо гээд ингээд оруулаад ирэхээр.

Тэгэхээр ер нь энэ хүчирхийллийн асуудлууд 3000 хүнтэй, 2000 хүнтэй сумын баг дээр илүү гараад байна уу хүн ам төвлөрсөн тэр болгон хүрч чадахгүй байгаа тэр газруудад илүү гараад байна уу гэдгийг та нар бас судалж үзсэн тийм судалгаа байна уу? Би бол 500 хүнтэй, 600 хүнтэй багийн дарга бол тэр 300, 200 өрхийг бол гарын 10 хуруу шигээ мэддэг юм. 7000, 5000-аас дээшээ гараад ирэхээр тэр багийнхан тэр хяналтаа алдчихдаг байхгүй юу үндсэн ажлаасаа. Гэтэл та нарын хууль дээр чинь сум хороо гээд ингээд нэг ийм хийсвэр биелэлт нь бол би тийм хангалттай байж чадах болов уу үгүй болов уу гэсэн нэг ийм зүйл орж ирээд байгаа юм. Тэгэхээр энэ 3 асуулт дээр би асуулт асууя гэж ингэж бодож байна.

П.Анужин: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нэг номерын микрофонд Баярмаа дарга хариулт өгье.

Н.Баярмаа: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ дээр гарсан сум хороо болгондоо анхан шатын нэгжтэй хүүхдийн асуудал хариуцсан хүүхдийн байгууллагаасаа арга зүйн удирдлагаар авдаг ажилтантай байх ёстой асуудал байгаа. Тэгээд энийг бол бид нар сум хороонд яг хүүхэд гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтныг хүүхдийн байгууллагаас нь томилон ажиллуулах, тухайн юуны тухайн орон нутгийн хүн амын тоо хүүхдийн эрсдэлт хүчин зүйлийн тоог тоонд харгалзан ЗГ шалгуур үзүүлэлт, аргачлал, орон тооны квотыг нь тогтоодог байх асуудлыг бол энэ хуульд оруулж ирсэн. Хамтарсан багийн санхүүжилтийн асуудлыг 2016 онд анх Хүүхэд хамгааллын хуульд хамтарсан баг явж байгаад сүүлд нь 12 сард Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдахад тийшээгээ ишилжсэн байгаа. Тэгээд үнэхээр энд хамт хамтарсан багийн санхүүжилт удирдлага зохицуулалтын асуудал нэг талдаа ХЗДХЯ, нөгөө талдаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам шиг хоёрдмол ийм байна. Орон нутгийн төсвөөс юм шиг, улсын төсвөөс юм шиг гээд. Тэгээд энэ асуудлыг шийдвэрлэхийн хүрээнд бид нар хамтарсан багийн энэ зохицуулалтыг Хүүхэд хамгааллын хууль дээрээ хамгааллын үйлчилгээ үзүүлэх эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд гэр бүлээ тодорхойлох, энэ үйлчилгээг нь бусад үйлчилгээнд холбон зуучлах, тэгээд зардлыг нь тооцдог байх, хамтарсан багийн гишүүдэд нь урамшууллыг нь оруулж тооцож олгодог байх энэ асуудлыг нь бол нэмэлтээр хамтарсан багийн чиг үүрэг гэсэн юун дээрээ Хүүхэд хамгааллын хууль дээрээ бас эргэж оруулж ирсэн байгаа.

Санхүүжилтийн асуудлыг бол түрүүн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 6-д хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилт гэсэн энэ бүлэг дээр болохоороо тухайн аймаг,

орон нутаг, улсын хүүхэд хамгааллын хүн амын орон тоо болон хүүхэд эрсдэлт нөхцөлд байгаа кэйсийн тоонд нь тулгуурлаж хуваарилдаг, төлөвлөдөг, хуваарилдаг, зарцуулдаг байх энэ зохицуулалт орж ирсэн. Тэгээд энэтэй уялдуулаад ганц хүүхэд хамгааллын санхүүжилт бол хүүхдийн байгууллага дээр төвлөрдөг биш, хүүхдэд тулж үйлчилгээ үзүүлдэг боловсролын сургуулийн орчны хамгаалал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хамгаалал, хэвлэл мэдээлэл цахим орчин, гамшиг онцгой үе, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгаалал гээд энэ орчнуудыг бас дэлгэрүүлж оруулж ирсэн байгаа. Тэгээд энэ хүүхэдтэй тулж ажилладаг байгууллагууд маань хүүхэд хамгааллын үйлчилгээгээ үзүүлнэ, дээрээс нь нэмээд хүүхэд хамгааллынхаа үйлчилгээнийхээ санхүүжилтийг тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийнхаа багцад тусгадаг, хяналтаа тавьдаг энэ зохицуулалтуудыг оруулж ирсэн. Тэгэхээр хүүхэд хамгааллын санхүүжилт бол салбар дундын зохицуулалттай болсон, зохицуулалттай болгох эрх зүйн зохицуулалтыг бас энэ хуулиараа оруулж өгч байгаа гэж бодож байгаа.

330 сум, 204 хороонд Сангийн яамнаас бид нар зөвшөөрөл авахдаа бол эхний ээлжид бид нар хуулийн зохицуулалтаар бол тухайн орон нутгийн хүн ам хүүхдийн тоогоор нь ЗГ квотоо хууль батлагдчих юм бол квотоо тогтоогоод нийгмийн ажилтнаа ажиллуулах асуудал байгаа. Тэгээд энд бол бид нар бол юугаар бол 330 сум сум хороондоо гэдэг энэ зохицуулалтыг бол бас оруулаад өгсөн. Тэгээд хэлэлцүүлгийн түвшинд бол энэ багийн асуудлуудыг эд нар ороод явах байх. Хууль батлагдсаны дараа ЗГ бол энийг аргачлал квотоороо нийгмийн ажилтны асуудалд нь ажиллуулах асуудлыг тогтоогоод санхүүжилт мөнгийг нь бол тухайн төсөв жилийнхээ энэ төсөв хүрээнд шийдээд явах асуудалтай байгаа.

Эцэг эхийн үүрэг хариуцлагын асуудал дээр бол гэр бүл дэх хүүхэд хамгааллын асуудал дээр 4, 5 заалтуудыг нэмж оруулж өгсөн байгаа. Тэгээд Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуулиар хариуцлагын асуудал тодорхой байгаа. Тэгээд хүүхдийн эрхийн улсын байцаагчдын шийдвэрлэсэн мянга гаруй зөрчлийн 76 хувь нь яг эцэг эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагчдаас шийтгэсэн, эцэг эхийн үүрэг хариуцлага шийтгэсэн энэ тоон мэдээлэлтэй байж байна. Тэгээд энэ асуудал дээр бид нар бас хүүхдийн эрхийн улсын байцаагчдынхаа квот.../минут дуусав/

П.Анужин: Баярмаа дарга асуултаа ойлгоод, яг асуултад тодорхой хариулаач. 76 хувьд нь энэ гэр бүлийн хүрээнд гараад байна гэдгийг ойлгосон шүү дээ. Та нар хурал эхлэхээс авхуулаад наадхаа ярьсан. Хариуцлага тооцсон кэйс байна уу гэж асуусан биз дээ ядаж. Идэрбат гишүүн өөрөө тодруулья асуултдаа. Булгантуяа сайд энэ мэргэжилтнүүдээ асуултдаа тодорхой хариулахыг бас та.

Ц.Идэрбат: Тэгээд ер нь эцэг эх эхийн үүрэг оролцоо хариуцлага бол бас туйлын чухал. Энд нэг хэдэн төрийн албан хаагчдын үүрэг юм шиг хэдүүлээ яриад байгаа. Тэгэхээр энэ хуулийн шинэчилсэн найруулга дээр энэ эцэг эхийн үүрэг роль эрх үүргийг бүүр нэг тодорхой тусгаж өгөөд тухайн хүний хүүхэд гэлээ гэхдээ тэр чинь Монгол Улсын иргэн учраас Монгол Улсын хуулиар тэр хүн хамгаалагдах эрхтэй, тэр хүнийг насанд хүртэл нь эцэг эх нь асарч хамгаалах үүрэгтэй. Тэрийгээ биелүүлээгүй эцэг эхийг яах вэ гэдэг тал дээр бас ярих цаг нь бол одоо болсон байх гэж ингэж бас боддог юм. Яг амьдрал дээр ингээд хараад байхад. Хүний хүүхэд юм шиг л ярьдаг зарим нь бол тийм, эрэгнээс төрчихсөн юм шиг ингээд яваад байдаг эцэг эхүүд зөндөө байгаа шүү дээ. Тийм. Тэгэхээр энэ тал дээр бол бас энэ хуулийн энэ шинэчилсэн найруулга дээр олигтойхон тусгаад өгөөч. 2 дугаарт би

тэр яг баг гэж яагаад хэлээд байгаа вэ гэдгийг бас та хэд маань ойлгоорой. Хууль ингээд батлагдчихвал ЗГ-ын журам чинь сум хороо гээд л явчихна шүү дээ. Тийм учраас баг гэдгийг оруулаад, тэгэхдээ багаа бас дотор нь ялгахгүй бол болохгүй, 300, 400 өрхтэй багт хэрэг байна уу үгүй юу, 3 мянга, 4 мянган өрхтэй.../минут дуусав/

П.Анужин: Тодруулгад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Булгантуяа гишүүн, Булгантуяа сайд хариулъя.

Х.Булгантуяа: Гэр бүлийн тухай хуулийг ХЗДХЯ-наас өргөн барих гэж байгаа. Энэ дээр ялангуяа эцэг эх байх эрхийг хасах тухай мөн дээрээс нь нэмээд сүүлийн үед нийт хүүхдүүдийн бараг 1/3 нь хамтран амьдрагсдын дундаас төрсөн хүүхдүүд байна гэсэн ийм тооцоо судалгаа байдаг. Энэ тохиолдолд бас хүүхдийн эрхийг хамгаалах зохицуулалтуудыг Гэр бүлийн тухай хуульд хийж ХЗДХЯ-наас өргөн барих гэж байгаа. 2022 онд гэхэд эцэг эх байх эрхээ хязгаарлуулсан тоо гэхэд нийтдээ 2, Зөрчлийн хуулиар гэхэд 2023 оны одоогийн манай байгаа тоогоор 8 эцэг эх, Эрүүгийн хуулиар шийтгүүлсэн тоонууд бол одоогоор манай дээр байхгүй байгаад байна. Тэгэхээр ийм байдлаар ер нь бол юу яаж байгаа. Тэгэхдээ энэ тоо мэдээллүүд бас заримдаа юутай байна хязгаарлалттай байна. Энэнээс ерөнхийдөө зөрчлийн тоог нь хараад нийт хүүхдийн эсрэг үүсэж байгаа кэйсийн тоог нь хараад зөрчил хянан шийдвэрлэгдсэн тоог нь харахаар нийт зөрчлийн 70 гаруй хувь нь 78 хувь нь хүүхэд гэр бүлдээ үйлдэгдэж байна гэхээр энэ тоо.../минут дуусав/

П.Анужин: Булгантуяа сайд гүйцээгээд хариулт өгье.

Х.Булгантуяа: Энэ манай хүүхэд хамгааллын ер нь энэ төрийн байгууллагуудын бүтцүүд нэг ийм юм билээ Байнгын хорооны дарга, эрхэм

гишүүдээ дандаа бид нар нөгөө Засаг захиргаа, нэгжгийн тухай хуулиараа явчихдаг. Манай бүтэц 400 мянган хүн амтай дүүрэг ч байсан адилхан, 40 хэдэн мянган хүн амтай аймаг ч байсан адилхан. Тэгээд энэ бол асар хол зөрөөтэй байхгүй юу. Мөн сургууль мөн адилхан. Жишээлбэл улсын хэмжээнд 688 ЕБС байгаагаас 1000-3000 хүртэлх хүүхэдтэй 194 сургууль байна. Яг л адилхан нэг нийгмийн ажилтантай. Тэгэхээр бид нар энэ хүн амын ачаалал гэдэгтэйгээ уялдуулж хийх ёстой гээд. Тэгээд бид нар нөгөө засаг захиргаа нэгжээрээ явах болчихоод энүүнийг зохицуулах орон зай авах гэж бид нар хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан хүүхдийн байцаагчийн орон тоог тогтоох шалгуур үзүүлэлтийг ЗГ тогтоохоор төсөлдөө тусгасан. Тэгэхээр үүнтэй холбогдуулж бид нар аймгийн төвийн сум, дээрээс нь нэмээд жишээлбэл Замын-Үүд бол нэг л сум. Гэхдээ энэ бол маш том сум гээд ингээд хүн амын ачаалал, тэнд гэмт хэргийн тоо эрсдэлийн байдлыг нь үнэлж ажилчдын орон тоог нь бид нар нэмж тавихаар бас тусгаж өгсөн байж байгаа.

Тэгэхгүй бол одоогийн манай хуулиар бол бид нар нэгжээрээ шууд засаг захиргааны нэгжээрээ явахаар нэг ийм асуудал бас үүсчхээд байгаа юм.

П.Анужин: Асуулт асуух гишүүдийн нэрсийн дараалалд Дамбын Батлут гишүүнийг хийж өгөхийг хүсэж байна. Балжиннямын Баярсайхан гишүүн асуулт асууна.

Б.Баярсайхан: Баярлалаа. Бид нар энэ Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хийхдээ мөрдөгдөж байгаа одоо хууль тогтоомж яагаад хэрэгжихгүй, яагаад хүүхдийн хүчирхийлэл буурахгүй ихсээд байгаа юм бэ, бид нарын бодлого зөв үү буруу юу гэдэг дээр дүн шинжилгээ хийх гэдэг нэг юмыг би амаа цангатлаа яриад байгаа шүү дээ. Тэгээд энэ дүн

шинжилгээ нь хийгдээд энэ шинэчилсэн найруулгын хууль орж ирж байна гэж үзэж 1 дүгээрт болж байна уу?

2 дугаарт энэ 16 оноос хойш НҮБ зөвлөмж өгөөд үнэхээр хүүхдэдээ багахан анхаардаг улс, дундхан анхаардаг улс гээд 21 онд бол бид нар манай Монгол Улсын ЗГ-ыг хүүхдэдээ анхаардаггүй, хангалтгүй анхаарч байгаа гэдэг дээр дүгнэлт хийчихсэн шүү дээ. Энэ НҮБ-ын зөвлөмжүүд энэ хуульд яаж туссан юм бэ?

Энэ хуулийн зорилгоосоо авхуулаад ер нь төдийлөн бас нэг нямбай ажиллаагүй гэж харагдаад байна. Жишээлбэл энэ хуулийн зорилго нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бий болгох гэнэ, байхгүй юм уу тийм ээ? Монгол Улсад байхгүй байсан юмыг үндэсний хэмжээнд бий болгох гэж байгаа юм уу? Тэгвэл өнгөрсөн энэ жилүүдэд бид нар яг юу хийсэн юм бэ? Энэ тогтолцоогоо бэхжүүлэх гэж орж ирэхгүй юм уу? Дээрээс нь энэ хамгаалах, дандаа яг хүчирхийлэлд өртсөний дараа хамгаалах л гэж яриад байгаа болохоос биш эрхийг хангах гэдэг энэ эрхэм энэ үүргийг нь жоохон өмнө талд нь ингэж тодотгож хэлж болохгүй юм уу? Тэгээд үндэсний хэмжээнд бүх нийтийн бүх хүний үүрэг гэдэг энэ зорилгоо ч гэсэн ингэж тодотгож өгөөгүйгээс нэг ийм сул, яг энэ нэг ийм нийгмийн энэ сенсацыг дарах гэж яарч байгаа мэт, одоо яаралтай горимоор орж ирнэ гэж байна. Яг хуумгай хууль батлах гэж байгаа юм бол юунд нь яардаг юм. Тэгээд энэ дээр яам өөрсдөө ажиллаач, ажиллаач.

Сая Оюунчимэг гишүүний асуусан тэр Төсвийн хууль зөрчихсөн хүмүүст хариуцлага тооцно гээд байх юм. Танайх тооцохгүй байгаа шүү дээ. Тэгвэл ямар хэнд, ямар хариуцлага тооцчихоод байгаа юм бэ? Эрүүгийн гэмт хэргээр шийтгэгдэж байсан хүнийг Тамгын газрын даргаараа агентлаг нь ажиллуулчихаад, ирж байгаа дарга болгондоо буруу мэргэжил арга зүйн

зөвлөгөө өгөөд ингээд даргыг нь тогтворгүй байлгаад, агентлаг нь ингээд ажиллахгүй байгаа асуудлыг та нар яг юу гэж харж байгаа юм бэ? Энэ 8 тэрбум, 14 тэрбум болоод л шийдэгдлээ юу тийм ээ? Хамтарсан багт мөнгө өгөөд байсан чинь хүрэхгүй байсан гэж тэгж худлаа ярьж болохгүй шүү за юу. Хамтарсан багт мөнгө өгдөггүй байсан. Тэр өгдөг байсан гэж худлаа тэр тайлан тооцоондоо оруулаад байгаа мөнгөө яг бодитоор өгөх юм бол харин ямар үр дүн гарах юм гэдгээ бас харах ёстой.

Бас нэг зүйл бол хамтарсан баг гээд л яриад байна. Та нар энэ сайдад хамтарсан багт ажиллаж байгаа Засаг дарга нар байнга солигддог гэдгийг энэ яамныхан хэлсэн үү? Хамтарсан багт улс төрийн албан тушаалтан ордог учраас яг хүүхдийн мэргэжил, хүүхдээ хамгаалах юун дээр нэг жоохон номын дуу сонсоод л овоо нэг ажилтай зүгширэх гэж байтал хамтарсан багийн гишүүд байнга солигдож байдаг. Ийм учраас энэ Америкаас оруулаад ирсэн энэ турилага чинь хэрэгжихгүй байгаа шүү дээ. Энэ чинь яг бодлого зөв үү л гэдгийг асуугаад байгаа юм. Бодлого дээрээ ямар ч үнэлээд үнэлгээ дүгнэлт хийхгүй байж та нар ингэж жил болгон төсөв нэмүүлнэ гэж орж ирдгээ болиоч. Тэгвэл яг ямар үндэслэл дээр энэ төсөв нэмэгдэх гээд байгаа юм бэ? Тэгэхээс биш яг энэ төсвийг жил болгон нэмүүлээд ийм итгэмжгүй хулгай хийдэг төрийн албан хаагч нарт боломж олгоод ингэж ажиллуулах тийм сонирхол бол надаа лав алга байна.

Хүүхдээ бодохоор төсвөө нэммээр байдаг. Та нар хүмүүсээ өөрчлөхгүй, хариуцлагаа тооцохгүй, бодлогодоо дүн шинжилгээ хийхгүй байгаа учраас төсөв нэмэх гэдэг нь дахиад л нэг хэдэн чононд хонь хадгалуулж байгаа юм шиг ингээд явчхаад байна шүү дээ. Ажлаа дүгнэ л дээ, үнэн үнэнээр нь хэл л дээ. Бодлогоо тодорхойлж гаргаж ир л дээ. Яг миний

энэ асуултад та нар нэг тодорхой хариулт өгөөч. Тэгээд би тодруулъя.

П.Анужин: 1 номерын микрофонд Баярмаа дарга хариулъя.

Н.Баярмаа: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Хуулийн дүн шинжилгээний дагуу яаж бодлогоо тодорхойлсон юм бэ гээд. Хүүхэд гэр бүлтэй ажиллах хүний нөөцийнхөө асуудлыг тодорхой болгооч. Хүүхдийн эрхийн тухай хуулиар үндсэн суурь зарчмын дагуу бүх салбаруудын үүрэг оролцоо бол хүүхдийн эрхийг үндсэн 4 хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох энэ 4 эрхийг Хүүхдийн эрхийн тухай хуулиараа бид нар бүх салбаруудад үүрэг оролцоог нь өгсөн байгаа. Хүүхэд хамгааллын хуулиараа энэ салбаруудын үүрэг чиг үүргийг салбар дундын уялдаа зохицуулалтыг тодорхой болгооч гэсэн ийм зөвлөмж байгаа. Тийм учраас бид нар ЗГ-аас авхуулаад төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, орон нутаг, орон нутагт ажиллаж байгаа орон тооны бус зөвлөлүүдийн хоорондын зохицуулалт нь ямар байх вэ хамгааллын үйлчилгээ ямар байх вэ гэдгийг илүү оруулж ирсэн.

Тэгээд хүүхэд хамгааллын бодлогыг тодорхой болгохын тулд хүүхдэд үзүүлж байгаа хамгааллын үйлчилгээ гэсэн энэ 4, 5 дугаар хуулийн төслийн 4, 5 дугаар бүлэг бол хамгааллын үйлчилгээгээ тодорхой болгоод хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх кэйс менежментийн асуудал нь ямар байх вэ гэдэг энэ асуудлыг бол илүү тодорхой болгож оруулж ирсэн. Орон нутгийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн үүргийг бас давхар Хүүхдийн эрхийн хуульд байдгаасаа илүү хамгаалал дээрээ илүү ямар байх вэ гэдэг үүргийг энэ Хүүхэд хамгааллын хуулийн юун дээрээ шинэчилсэн найруулга дээрээ илүү тусгайлж бас оруулж өгсөн байгаа. Тэгээд салбаруудад хүүхэд хамгааллын үйлчилгээг яаж үзүүлэх вэ гэдэг энэ

асуудлыг илүү процессын болгож, үйлчилгээг кэйс менежментийн явцыг нь тодорхой болгох ийм чиг үүргийн зөвлөмжүүд өгсөн учраас оруулж ирсэн.

2016 онд байгуулагдсан энэ ГБХЗХГ-ын хүний нөөц нь нэмэгдээгүй гэсэн ийм асуудал байгаа. Тэгэхээр энэ яг энэ хүүхэд гэр бүлийн байгууллагын чиг үүргийн хүрээнд анхан шатдаа хамтарсан багт ажилладаг нийгмийн ажилтантай байх энэ асуудлуудыг бас энэ хуулийн шинэчилсэн найруулгын хүрээндээ илүү тодорхой болгож бас оруулсан. Хамтарсан багийн гишүүдийн асуудал бол Баярсайхан гишүүний хэлж байгаа үнэн. 2000, хамтарсан багийн дарга нар бол улс төрийн албан тушаалтнууд орон нутгийн сонгуулиар сонгогддог. Жил болгон манай ГБХЗХГ-аас хамтарсан багийн үндэсний хэмжээний сургалтыг явуулж байна. Ажлын байран дээр сургах асуудлыг хийж байна. Энэ судалгаагаар бол 67 хувь нь бас шинэчлэгддэг, тогтвор суурьшилтай байна гэдэг муутай байна гэдэг судалгаа бий. Тэгээд энэ дээр бол бид нар бол ажлын байран дээр сургах асуудал, орон нутагт нь очиж явах асуудал, өнгөрсөн жил бол нийслэлийн 204 хороо дээр Гэр бүл, хүүхэд залуучуудын газар, Нийслэлийн ГБХЗХГ бол ажилласан, ажилласан байгаа. Тэгээд сургаад явж байгаа, сайн ажиллаж байгаа хамтарсан баг ч гэсэн байгаа.

Энэ хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд бол хамтарсан багийн чиг үүргийн асуудал бусад үйлчилгээтэйгээ бусад байгууллагуудтайгаа яаж уялдах вэ гэдэг асуудал орж ирсэн. Санхүүжилтийн асуудлыг нь ч гэсэн хүүхэд хамгааллын санхүүжилтийн асуудлыг нь хүүхэд хамгааллын улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг байх энэ асуудлуудыг бол бас цогцоор нь оруулж ирсэн. Хүүхэд хамгааллын үйлчилгээний энэ цогц үйлчилгээ салбар дундууд ямар

үйлчилгээ үзүүлэх вэ гэдэг асуудлыг бас оруулж ирсэн байгаа.

Хүүхэд хамгааллын дүн шинжилгээгээр бас алслагдсан энэ харьяалал харгалзахгүй үйлчилгээ үзүүлэх байх ёстой гээд. Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ гэдгийг бас тодорхойлж оруулж ирсэн. Алслагдсан бүс нутагтаа хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг салбар дундаа хамтарсан багаар яаж үзүүлэх вэ гэдэг асуудал мөн хуулийн үйлчлэх хүрээндээ болон Монгол Улсын нутаг дэвсгэрт төдийгүй харьяалал харгалзахгүй бүх хүүхдэд үйлчилгээ үзүүлэх энэ асуудлыг нь бас илүү тодорхой болгож хүрээгээ өргөтгөж оруулж ирсэн байгаа.

П.Анужин: Энэ нөгөө бөөсний үлгэр шиг л ингээд нэг юмаа давтаж тойроод асуугаад байх юм. Өмнөх хууль дээрээ дүн шинжилгээ хийгээд, тэдгээр хуулийн алдагдал тэр доголдуудыг яг нөхөхүйц тийм хууль концептын хувьд болсон юм уу гэдэг тодорхой асуулт байгаад байна шүү дээ. Энд ийм урт юм хэрэггүй. 2 дугаарт тэр хариуцлага тооцсон юм уу тооцоогүй юм уу гээд асуугаад байх юм. Монгол хэлээр. Тэгэхээр Булгантуяа сайд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Булгантуяа сайд хариулъя.

Х.Булгантуяа: Хуулийн зорилгын хүрээнд энэ хуулийн зорилго нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, бүрэлдэхүүн хэсэг, оролцогч талуудын чиг үүргийг тодорхойлох, бий болгох биш хүүхдийн эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн сайн сайхан байдлыг хангахад оршино гэж энэ хуулийн зорилго нь байгаа. Мэдээж энэ бол 2016 онд энэ хуультай болж, бүтэцтэй болж бид нар бас ахиц дэвшил гарсан уу гарсан. Тэгэхдээ сайжруулах зүйлүүд байгаа юу байгаа. Энүүнийг НҮБ-аас гаргасан энэ Хүүхдийн сангаас хийсэн энэ хууль дээр хийсэн үнэлэлт

дүгнэлт, дараагийн ажлын энэ зураглал, ХЭҮК-ын сүүлийн 2 удаагийн тайлан дээр хүүхдийн эрхийн тухай, ялангуяа энэ хамтарсан багийн үйл ажиллагааны тухай нэлээн нарийн заасан байдаг. Эдгээрийг бид нар аль болохоор бүгдээрэнг нь л энэ хуульд зохицуулалтуудыг нь хийж өгөх гэж, кэйс менежмент дээр ажилладаг хүмүүсийнхээ санхүүжилт нь дутуу ХЗДХЯ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын дунд энэ хаягдаад байгаа кэйсийнх нь санхүүжилтийн тооцооллыг нь бас үнэнийг хэлэхэд төдийлөн сайн хийж чаддаггүй байсан нь өмнө нь бас аудитын дүгнэлт гаргахад бас нөлөөлсөн байсан.

Олон өрхүүдэд ингээд очиход үл хайхрахаас үүдээд, тэр хүүхэд дээр очиход хамтарсан баг очиход ядаж нэг гурилан боовтой хүртэл очихоос өөр аргагүй байдаг. Хэчнээн хоног хаягдчихсан. Тэгээд одоо ингээд л арай ч өвс тэжээл авах нь хаашаа юм. Тэгэхдээ хүнс тэжээлийн заримдаа наад захын багцыг авч очдог. Тэгэхээс өөр аргагүй нөхцөл байдалтай бас байгаа. Юуны хувьд 2016 оноос хойш миний ойлгосноор тэр хүмүүстэй нь хариуцлага, би тэр үеийн дарга байгаагүй болохоор мэдэхгүй байна. Тэгээд энэ хэн олон дарга нар нь хариуцлага тооцогдоод ажлаа өгсөн, одоо нягтлан нь гэхэд чинь дөнгөж саяхан шинэ санхүүгийн хүн дөнгөж саяхан шинээр томилогдсон. Одоо хэрвээ тийм эрүүгийн юмны асуудал энэ тэр байгаа бол Төрийн албаны тухай хууль ноцтой зөрчсөн асуудал байгаа бол та бүхэн ч гэсэндээ шүгэл үлээгээд ТАЗ-д, АТГ-т бас өгөөч. Тэр бол бид нарын бүрэн эрхийн асуудал.

16 оноос хойш жил болгон хийсэн аудитын тайлан нь ил байгаа. Манай яамны веб сайт дээр байгаа. Би сошиал дээр ч гэсэн бас тавьсан. Жил болгон бол энэ хязгаарлагдмал дүгнэлттэй гарсан нь бол үнэн. Хамгийн гол нь энэ арга аргачлал, санхүүжилтийнхээ арга аргачлалыг зөв хийж чадаагүйгээс

үүдээд энэ дээр актууд тавиад байна гэж намайг Сангийн яаманд байж байхад л энэ Хүрэлбаатар сайдын үед бид нар бас ийшээ орж юу хийж байсан, аудит хийж байсан. Сая бид нар арга аргачлал дээр нь олон улсын байгууллагуудтай хамтраад, Сангийн яамтай хамтраад бас нэлээдгүй ажиллаад нэг кэйс үүсгэхэд эхнээс нь эцэс хүртэл нь яаж явах вэ гэдэг санхүүжилтийнх нь аргачлал тооцооллыг гаргаж ирээд, энийг хамтарсан байдлаар батлаад явахаар.

Энэ ХЗДХЯ-ны зөвлөмжийн дагуу бусад хуулиуд дээр байгаа асуудлуудыг дахиж энэ хууль дээр дурдахгүйгээр уг нь бол хийсэн юм. Тэрнээс биш яах вэ бүгдээрэнг нь бид нар энэ рүү оруулж өгч болно л доо. Тэгэхээр нөгөө Гэр бүлийн тухай тэдийн тэдийн дагуу энэ дээр хариуцлага хүлээнэ. Тэр Зөрчлийн тухай хуулийн тэдийн тэдийн дагуу хариуцлага хүлээнэ гэж тийм болчих гээд байдаг. Их Хурлын Тамгын газар ч гэсэндээ үүнийг юуны Хууль тогтоомжийн хуулийн дагуу бусад хууль дээр энэ дурдагдсан бол заавал үүнийг нэг нэгэнгүй энд тоочих шаардлагагүй гэж үзсэн. Тэгээд энд ажиллаж байгаа энэ хамтарсан багийнхан бол бүгд л төрийн албан хаагчид шүү дээ. Зарим нь бол яах вэ улс төрийн албан тушаалтнууд байгаа. Яах вэ Засаг дарга байгаа гол шалтгаан нь энд чинь хорооны нийгмийн ажилтнаас авхуулаад, хэсгийн ахлагч нараас авхуулаад, цагдаагаас авхуулаад хүмүүс ажилладаг энэ хамтарсан багт. Манай нийгмийн ажилтны үгэнд удирдлага дор цагдаа энэ тэр хөдөлнө гэхэд их хэцүү байхгүй юу. Тэгэхээр хорооны Засаг дарга, дүүргийн Засаг дарга, аймгийн Засаг дарга гэдэг ийм албан тушаалтан энэ бүтэн багийг хөдөлгөвөл илүү хүүхэд хамгааллын төлөө хурдан шуурхай, төсөв санхүү ч гэсэн шийдэгдэхэд илүү боломжтой юм болов уу гэж бодож байгаа.

Зарим улс оронд энэ хүүхэд хамгааллын байгууллага бол цагдаа шиг

эрхтэй, цагдаагаас хүчтэй ч эрхтэй байдаг. Бүүр цагдааг дуудаж мэдүүлэг авдаг, юу өгдөг ийм байдаг. Манайд бол одоохондоо ийм тогтолцоо энэ хуулийн дагуу дөнгөж энэ хүүхэд хамгааллын тогтолцоо чадан ядан 8.../минут дуусав/

П.Анужин: Баярсайхан гишүүн Балжиннямын Баярсайхан гишүүн тодруулж асууя.

Б.Баярсайхан: Тэгэхээр яг сая Булгантуяа сайдын хамгийн сүүлд хэлсэн яг наад тогтолцоог чинь л одоо бид нар хиймээр байгаа юм. Жишээлбэл ХЭҮК-ын хүний эрхийн ахлах мэргэжилтэн гэдэг шиг байнгын тогтвортой зөвхөн хүүхэд хамгааллын асуудлаараа дагнаж ажилладаг энэ мэргэшсэн хүмүүс дээр энэ нэмүүлэх гэж байгаа төсвөө батлуулаад, ингээд тэр хүүхдийн эрхийн байцаагчаас ямар ч албан тушаалтан хүүхдийн эрхийг хангахад айдаг эмээдэг хариуцлага тооцогддог ийм байж л бид нар одоо цаашаа явахгүй бол, одоо болоогүй гэж хэлж болохгүй. Тэгэхлээр хэзээ болох юм. Яг энэ хэрвээ шинэчилсэн найруулга гэж орж ирж байгаа бол өнөөдрийн цаг үедээ таарсан, тохирсон тэр шинэчилсэн бодлого, шинэчилсэн өөрчлөлт, өөрчлөлт шинэчлэлт авчрах тийм л хууль байх ёстой л гэж ингэж хараад байна л даа. Тэгэхээр энийгээ зоригтой бас хийчихмээр байна. Тэгээд энэ хуулийн үйлчлэх хүрээнд Монгол Улсын харьяат хүүхэд гэдэг санаа огт тусгагдаагүй байна. Тэгээд энэ хууль хэлэлцэхэд бол нарийн ширийн олон санал, асуултууд байна. Тэгээд хугацаа.../минут дуусав/

П.Анужин: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууя.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Хурлын даргад баярлалаа бас нэр оруулж өгсөнд. Чухал хууль хэлэлцэж байна. Тэгээд бас энэ хууль маань өөрөө ингээд шинэчилсэн найруулгын төсөл болоод ороод ирж байгаад бас баяртай байна. Энэ 3.3 дугаар зүйл дээр эрүүл мэндийн салбар

дахь хүүхэд хамгаалал гэсэн зүйл байгаа. Энэ дээр бол нэг хэлэх гэсэн санаа бол энэ охидын мэргэшсэн эмчийн асуудлыг бид ер нь ярьж байхгүй бол энэ хамгийн хаягддаг сэдэв. Ялангуяа өсвөр насны охидын мөстөрцөлтэй холбоотой, дээрээс нь бэлгийн гаж хөгжил ч байдаг, дээрээс нь гэмтэл бас бэлгийн хүчирхийлэлд автагдах, гэмтэх, урагдах, язрах гээд л олон гэмтлүүдийг хуучин эрүүл мэндийн тогтолцоо бол заавал мэдээлдэг ийм байсан. Одоо ийм мэдээллийн тогтолцоо амьд байна уу, байхгүй юу гэдгийг нэгд асуумаар байна.

2-т бид энэ эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал сэдэв дотор ялангуяа та бүгдийн энэ гаргасан энэ зураглал дотор бид энэ өрхийн эмнэлэг, тосгоны эмнэлэг, сум дундын эмнэлэг буюу анхан шатны эмнэлэгт тухайн эмч нь охидын эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн байх эсхүл давтан сургалтад хамрагдсан байх өөрөө аягүй чухал байхгүй юу. Тэнд жинхэнэ охидод зөвлөгөө өгөх сэтгэл зүйч маягтай ажиллах, дээрээс нь эмэгтэйчүүдийн үзлэг хийдэг байх гээд ийм зүйлийг бүүр онцгой анхаармаар байгаа юм. Тэгэхээр би бас энэ ажлын хэсэг гараад ажиллахаар энэ чиглэлд бас энэ эрүүл мэндийн хэсэг зүйл дээр бол оруулаасай гэж хүсэж байна. Түрүүн нэг асуусан зүйл нь тэр.

2 дахь зүйл бол энэ Үндсэн хуульд бол Үндсэн хуулийн дагуу иргэнийхээ хувьд хүүхэд амьд явах гэж байгаа шүү дээ, эрүүл байх энэ эрх үүрэг. Тэгэхээр бид Монголдоо эмчилж чадахгүй байгаа өвчнүүдийг ялангуяа эхнээс нь хүүхдүүддээ бүрэн эмчилдэг байх. Эсвэл Монголдоо эмчилж чадаагүй бол өөр оронд очоод эмчлүүлэхэд тэр өртөг зардлыг нь бүрэн даадаг байх энэ асуудлыг бид хөндөж яримаар байгаа юм. Энэ бол хүүхдийн эрхийн асуудал шүү дээ. Тийм учраас бид энэ хуулийн хүрээнд бас энэ төсөлтэй холбоотой энэ асуудлыг хөндөж ярьж, тэр битгий хэл хүүхдийн дэмжих сан хэдэн тэрбум

төгрөг байна л гэж байна. Тэгвэл зүгээр урьдчилсан зүгээр нэг тоо баримжаа судалгаагаар үзэхэд жилдээ бид нэг ойролцоогоор 10 тэрбум төгрөг гаргачихсан байхад 100 гаруй хүүхдийг гадаадад эмчлүүлээд байх буюу 100 сая гаруй төгрөгийг бүрэн даагаад байх ийм боломж байгаа байхгүй юу.

Тэгэхээр бидэнд уул уурхай байлгаас орж ирж байгаа энэ их мөнгөнүүдийг бид хүүхдүүдээсээ хамгаалж чадахгүй, дээрээс нь хамгаалж болохгүй, дээрээс нь эмнэлэг нь өөрөө эмчилж чадахгүй гэж зарлаж байгаа бол бүрэн даадаг байх тал дээр бас анхаармаар байгаа юм. Би энэ тал дээр бас Булгантуяа сайдын саналыг сонсмоор байгаа юм. Тэгээд хариулт авчхаад тодотгоё.

П.Анужин: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Булгантуяа сайд хариулъя, хариулт өгье.

Х.Булгантуяа: Хүүхэд хамгааллын хамтарсан багт бол бас өрхийн эрүүл мэндийн энэ бас эмнэлгээс бол ордог. Энүүхэндээ гэж хэлэхэд манай бас эрүүл мэндийн салбарынхан маань үүн дээр бидэнд бид бас энэ дээр мэдээлэл сурталчилгаа сургалт бас нэлээдгүй хийх ёстой харагдаж байгаа. Насанд хүрээгүй хүүхэд жирэмсний хяналтад байж байгаа төрөхөд Эх нялхсын эрүүл мэндийн төвөөс бид нарт мэдээлэл өгч байна уу гэхээс биш нөгөө дүүргийн эрүүл мэндийн эмнэлгээс байдаг юм уу, эмчээс бид нарт мэдээлэл өгөхгүй байна. Дээрээс нь нэмээд хүүхэд, гэмтэл энэ тэр авсан байхад бас мэдээлэхгүй байгаа, мэдээлэл нь ингээд дарагдаж явсаар байгаад хүндэрсэн ийм асуудлууд бас нэлээдгүй гардаг. Тийм учраас манай хууль дээр хүүхдийн хамгааллын хүүхэд хамгааллын хувийн хэрэгтэй больё гэж байгаа юм. Энэ хувийн хэрэгт цагдаа, эрүүл мэндийн байгууллага, сургуулийн нийгмийн ажилтан, хорооны нийгмийн ажилтныг

гэр бүл хүүхэд хөгжлийн энэ хариуцсан ажилтан ордог.

Хэрвээ тухайн хүүхэд удаа дараа гэмтэлд өртөөд өрхийн эмнэлэг дээрээ ч байдаг юм уу, аль нэг эрүүл мэндийн байгууллага дээр ирэхэд тухайн хүүхэд дээр энэ хүүхэд нэг л биш байна шүү анхаарал хандуулаарай гээд эрүүл мэндийн салбар тэрэн дээр анхааруулга тавихад бусад бүх хүүхэд хамгааллын ажилтнууд нь цагдаагаас авхуулаад үүн дээр анхаарал хандуулдаг бид нар ийм юуг бас оруулж өгсөн. Ер нь яах вэ нөгөө ХЭҮК-оос өгсөн олон зөвлөмжийн дагуу бид нар жишээлбэл охидын үзлэгээс авхуулаад олон зүйлүүдийг хийхэд бас их амаргүй байгаад байгаа. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулиас авхуулаад холбогдох хуулиудад энийг хийгээд өгвөл бид нарын хувьд бол бас их зүгээр байгаад байна. Энийг ганцхан Хүүхэд хамгааллын тухай хууль гэхгүй эрүүл мэндийн салбарын бас хуулиудад оруулж өгөх нь органик хуулиуддаа бас их оруулах нь бас их юутай байгаад байгаа.

Ер нь эрүүл мэндийн байгууллагын ажилтан нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хэрвээ хохирол учирчихсан бол холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээнэ гэж бас бид нарт оруулж өгсөн. Тэгэхээр Эрүүл мэндийн тухай хуулиасаа авхуулаад Хүүхэд хамгааллын тухай хуульд хэрвээ төрийн албан хаагч байх юм бол Төрийн албаны тухай хуулийн дагуу үүрэг хариуцлагыг бол хүлээнэ гэсэн үг. Мөн эрүүл мэндийн салбар өөрөө хүүхэд хамгааллын бодлоготой байх ёстой. Тэгээд энэ зардлыг жил бүр өөрийнхөө төсөвтөө түсгуулах энэ арга хэмжээг авах ёстой гэж бид нар бас тусгаж өгсөн байж байгаа.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний мэдээллийн санг бид нар бас бүрдүүлж байгаа. Ер нь манай нийт хүүхдүүдийн 36 орчим хувь

нь нийгмийн халамж хамгаалал шаардлагатай айл өрхүүдэд байна. Энэ оны эхний 8 сарын байдлаар 70 мянга орчим дуудлага 108 дээр ирснээс түүний талаас илүү нь зорилтот дуудлагууд байна гэдэг бол хүүхдийн эсрэг хүүхэд бас эрсдэлд байгаа тоо бол бас нэлээдгүй өндөр байна. Тэгэхээр хүүхэдтэй харьцаж ажилладаг ойрхон ажилладаг хүн болгон энэ дээр л ажиллахаас өөр аргагүй гэсэн үг. Яах вэ манай юун дээр бол хууль дээр бүүр эрүүл мэндийн ажилтан тэрүүний чиг үүрэг гэдэг юмнуудыг бол төдийлөн нарийн бас оруулж өгөөгүй.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хуулиуд дээр санхүүжилтийг бүүр хүүхдийг номер нэгээр байдаг юм уу оруулаад өгвөл энэ дээр бол маш их тус нэмэртэй. Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль орж ирж байгаа тийм ээ. Дээрээс нь нэмээд ЭМД-ын тухай хууль гэх мэтчилэн бусад хуулиуд дээр бас суугаад өгчихвөл.../минут дуусав/

П.Анужсин: Чинбүрэн гишүүн асуултад тодруулга авъя.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр тийм охидын эмч гэж бүр байхгүй болчихоод байна л даа тийм ээ. Тэгэхээр тэрийг нэг сургах асуудал. Дээрээс нь мэдээлэл, одоо янз бүрийн бэлгийн хүчирхийлэлд автагдсан талаар мэдээлдэг тэр эмнэлгийн байгууллагууд заавал мэдээлэх гэдэг энэ журам ажиллаж байна уу, тийм мэдээлэл ирж байна уу, мэдээлэл ирж байгаа бол тийм тоо баримт хэлж болж байна уу гэдэг нэг.

2-т сая тэр нөгөө хүүхдийн сантай холбоотой тэр санхүүжилтийг энэ эрүүл мэндийнх нь юунд нь зарцуулах тэр гаргалгаа үүгээрээ дамжуулан хийх боломж бий юу гэдэг энэ 2 асуултад хариулт явъя.

П.Анужсин: Сайд Булгантуяа хариулна.

Х.Булгантуяа: Тэр Чинбүрэн гишүүн их чухал асуулт асуугаад байна. Нэгэнт улс нь өөрөө эмчилж чадахгүйгээр зарлагдсан бол зардлыг бүрэн даадаг байх талаар. Энэ бол Арабын орнуудад ер нь бараг Монголоос бусад бүх орнуудад хэрэгждэг ийм зүйл шүү дээ. Тэгэхээр энэ дээр боломж гарц гаргалгаа нь байгаа юм уу гэдэг дээр Булгантуяа сайд хариулт өгье.

Х.Булгантуяа: Харин тийм. Яах вэ хүүхэд Хүүхдийн төлөө фонд гэж байж байгаад Хүүхдийн төлөө сан болоод энэ дээр 11 орчим тэрбум төгрөг хуримтлагдсан. Нийтдээ Азийн дугаараас нийтдээ 3, 4 тэрбум төгрөг жилд хуваарилагдаж юу орж ирж байгаа орлого болж орж ирж байгаа. Анх энэ фонд үүсээд манай яаман дээр фонд байгаад манай яаман дээр сан болж орж ирэхдээ 2 орчим тэрбум төгрөгийн орлоготойгоор ирсэн. Эндээс хүмүүс ингээд нөгөө бусад сангуудыг тоносонтой адилхан алга болчихсон юм биш биз дээ гэж яриад байгаа юм. Энэ сангаас бол өмнө нь олон улсын тэмцээн уралдаанд орохтой холбоотой мөн хүүхдийн юуны зам тээврийн хөдөлгөөний мэдлэг мэдээлэл өгөхтэй холбоотой нэг.../минут дуусав/

П.Анужин: Булгантуяа сайд гүйцээж хариулъя.

Х.Булгантуяа: Үүнтэй холбоотойгоор 1 тэрбум орчим гаруй төгрөгийн шийдвэр гарсан. Бусад мөнгө нь бол байгаа. Үүнийг өгсөн ялангуяа хандив өгсөн хүмүүс нь бол хүүхэд рүү чиглэсэн дорвитой хөрөнгө оруулалт хийгээсэй гэж хүсэж өгч байсан юм байна лээ. Яг тэр үеийн хандив өгч байсан хүмүүс, тавьсан хүсэлт гээд хамгийн түрүүнд үнэнийг хэлэхэд манай төрийн бус байгууллагууд ч, иргэд ч гэсэн үүнд бол маш их хандив өгсөн. Тэгээд ялангуяа хүүхдийн ордон байгуулаасай, хүүхэд рүү чиглэсэн эмнэлэг байгуулагдаасай гэсэн ийм байдлаар

урсгалаасаа илүү. Урсгал дээр бол эрүүл мэндийн сан, ЭМД-ын сан гэх мэтчилэн сангууд бол уг нь нэлээдгүй байгаа. Тэрүүний санхүүжилтийн журмыг улам сайжруулаад, магадгүй 1 дүгээрт хүүхэд байхаар энэ хуулийн зохицуулалтыг хийж өгвөл илүү үр дүнтэй юм болов уу гэж. Энэ чинь жилдээ одоо жишээлбэл энэ азын дугаараас ганцхан хэрвээ харах юм бол жилд 3 тэрбум төгрөгөөр, 3 тэрбум төгрөгөөр чинь нэг 100 хүүхдийн цэцэрлэг ч барьж чадахгүй болчихоод байна шүү дээ 2 давхар.

Тэгэхээр энэ бол ганцхан хүүхдүүд рүү чиглэсэн эрүүл мэндийн салбарын зардал биш. Бусад бас эх үүсвэрүүдийг эрүүл мэндийн салбарын эх үүсвэрийг Эрүүл мэндийн тухай хуульд нь тусгаж өгвөл илүү зүйтэй юм болов уу гэж харж байна.

П.Анужин: Тоо баримт түрүүн тодорхой асуусан тийм ээ. 1 номерын микрофонд Баярмаа дарга хариулъя.

Н.Баярмаа: Одоо хэрэгжиж байгаа Хүүхэд хамгааллын хуулиараа эрүүл мэндийн ажилтан эмчилгээ үйлчилгээ үзүүлэх явцдаа хүүхдийг эрсдэлт нөхцөлд орсон хүчирхийлэлд өртсөн бол.../үг тасрав/

П.Анужин: Микрофондоо ойрхон яримаар байна.

Н.Баярмаа: Мэдээлэх чиг үүрэгтэй байгаа. Тэгээд одоогийн байдлаар сүүлийн үед бол хүүхдийн тусламжийн утсанд өнгөрсөн жил 13 эрүүл мэндийн нийгмийн, эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдээлсэн гэсэн тоон мэдээлэлтэй. Энэ дээр бол бид нар салбар дундын зохицуулалтыг бас ханган ажиллаж байгаа. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу бол Эрүүл мэндийн сайдын баталсан журам байгаа. Тэгээд энэ журмын дагуу бол мэдээллийн үйлчилгээний мэдээллийн нэгдсэн санг

бол бий болгохоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр И-тусламж гэсэн энэ гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн мэдээллийн сан байгаа. Дуудлага дуудах мэдээлэх тоо бол өнгөрсөн жилийн байдлаар бол 13 эмнэлгийн байгууллагын ажилтан мэдээлсэн гэсэн тоотой.

Тэгээд энэ хуулийн шинэчилсэн найруулгаар бол журамтай байх, мэдээллийн сантай байх, үйлчилгээ үзүүлэх зардал нь Эрүүл мэндийн сайдын багцад тусах ийм эрх зүйн зохицуулалтууд шинээр орж байгаа.

П.Анужин: Чинбүрэн гишүүний асуусан асуулт хүүхдийн эрүүл мэндийн, хэдийгээр эрүүл мэндийн асуудал гэж байгаа ч гэсэн бид нар өнөөдөр хүүхэд хамгааллын цогц бодлогыг ярьж байгаа. Тэгэхээр энэ маань эрүүл мэндийнхээ бусад хуулиудтай хэрхэн уялдах вэ, ямар бодлого баримталж байгаа юм гэдэг бодлогын шинж чанартай асуулт асууж байхад энийг бол бас үгүйсгэх эрх бол та нарт байхгүй. Бид нар хүүхэд хамгааллын цогц бодлогыг өнөөдөр энд ярьж байна. Дамбын Батлут гишүүн асуулт асууя.

Д.Батлут: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Мааш чухал асуудал хэлэлцэж байна. Тэгээд яах вэ бид нар нэг талаасаа энэ хууль дээрээ төрийн байгууллагын бүтэц тэр чиглэлийн бас үйл ажиллагааг нэлээн чухалчилж тавьж өгсөн. Салбар салбарын зохицуулалтууд хийгдсэн, хамгааллын бодлого нь яг салбар салбараар хэрэгжинэ гээд ингээд гаргаад өгчихсөн байна л даа.

Яг үндсэндээ бид нарт мэдэхгүйн зовлон их байгаад байгаа юм. Төрийн хууль тогтоох байгууллага болоод гүйцэтгэх байгууллагууд нь ерөнхийдөө асуудлуудаа нэлээн сайн мэдчихдэг. Иргэд бол пак шүү дээ яг үнэндээ. Мэдэхгүй байгаа хүмүүс ямар эрх үүрэгтэйгээ ч ойлгохгүй явж байгаа яг

үнэндээ. Тэгэхээр бид нар энэ томоохон бүтэц гаргаад ажиллаад байдаг, ажиллаад байдаг гэж байгаа юм. Өнөөдрийнхөө хуулийн зорилтод бол хүүхэд хамгаалах төрийн байгууллагын бүтэц тогтолцоо чиг үүрэг бүхий түвшинд тодорхойлогдож, хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжлийн түвшинд шаардлагатай хүүхэд бүрд хүргэнэ гээд томъёолчихсон байна. Одоогийн байгаа бүтэц чинь тэгээд яг энэ нөхцөл байдлаа хангаж чадах юм уу? Өнгөрсөн энэ жил бид нар 8 тэрбум төгрөг байх даа хүүхэд хамгааллын чиглэлээр баталж өгсөн санагдаж байна.

Яг энэ өөрөө нийгмийн соён гэгээрэл, энэ хуулийг хэрэгжүүлэх тал дээр иргэд рүү, нийгэм рүү чиглэсэн ямар үйл ажиллагаа энэ мөнгөн дээрээс гаргаж хэрэгжүүлсэн юм бэ? Улс орон даяар шүү. Дор хаяж бид нар энд гоё юм яриад баталдаг, тэрийг хэрэгжүүлж байгаа субъектүүд нь хангалтгүй ажилладаг ч юм уу эсвэл мэдэх ёстой хүмүүс нь ойлгохгүй мэдэхгүйгээс энэ чинь ямар ч үр дүнгүй зүйл болж хувираад байгаа шүү дээ. Мэдүүлэхийн тулд бид юу хийсэн юм бэ? Тухайлбал энэ 8 тэрбум төгрөгийн хэдий хэмжээний мөнгө нь тэр нийгмийг соён гэгээрүүлэх, энэ хүүхэд хамгааллын чиглэлээр иргэдэд мэдээлэл өгөх, хоорондын харилцаа холбоо тогтоох үйл ажиллагаатай холбоотой зардалд зарцуулагдсан юм. Магадгүй энэ хуулиар ингээд олон зохицуулалтууд хийгээд явж байгаа. Ингэснээрээ төсвөөс тодорхой хэмжээний хөрөнгийн эх үүсвэр шаардана гэж байгаа. Ингэснээрээ бүрэн дүүрэн бид нар энэ хүүхэд хамгааллын асуудлаа шийднэ гээд тодорхойлчихсон байх шиг байна л даа. Тэгвэл төсөв дээр ямар хэмжээний ачаалал нэмэгдэх юм бэ? Энэ тал дээрээ нэг хариулт өгөөч. Тодорхойлсон зүйл байгаа бол.

2 дугаарт нь энэ хэвлэл мэдээлэл тэр дундаа цахим орчин дахь хүүхэд хамгаалал. Өнөөдөр 2, 3 настайгаас

авхуулаад л гар утсаараа аягүй бол тоглоно, гар утсаар янз бүрийн мэдээлэл үздэг тийм ээ. Энэ бүхнийг бид нар хэрхэн хянах юм бэ, хэрхэн хянах юм. Янз бүрийн буруу хазгай сувгийн мэдээллүүдийг ч гэсэн гар утсаараа хэн ч гэсэн авах боломжтой байгаа. Би яах вэ энэ уншлаа л даа. Та бүхний амнаас сонсмоор байна, яг яаж төсөөлж ойлгож энэ хууль эрх зүйн зохицуулалтуудаа гаргасан юм бол гэж. Бид нар яг энэ цахим тал дээрээ, хүүхэд хамгааллын хүүхдэд буруу ойлголт төрүүлэхээр сэтгэл зүйд нь нөлөөлчихөөр тийм мэдээ мэдээллийг гаргуулахгүй байх тал дээрээ хэрхэн хамгаалалт хийж ажиллах юм, яаж зохион байгуулах юм, бүрэн дүүрэн хамгаалж чадах юм уу энэ дээрээ. Энэ дээр нэг хариулт өгөөч.

3 дугаарт нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн 358 хохирогч байгаа. Түүний энэ хүүхдүүдийн 70 орчим хувь нь гэр бүлийн орчны ураг төрлийн хүрээнд гарсан байна гээд. Цаашилаад ийм нөхцөл байдалд байгаа хүүхдүүдийн судалгаа гэж ер нь гардаг уу? Энэнээс бид нар урьдчилан сэргийлэх чиглэлээр жишээлбэл хүүхэд хамгааллын байгууллага энэ хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр яаж ажилласан юм бэ, өнгөрсөн хугацаанд. Урьд жил нь ямар байсан юм, одоо ямар, ямар түвшинд хүрчхээд байгаа юм бэ? Бид нарт ахиц гарсан юм уу?

П.Анужин: Батлут гишүүний асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Булгантуяа хариулт өгье.

Х.Булгантуяа: Нэмээд хариулчхаарай, хэн Өлзийхутаг дарга хариулах уу? 3 номер. Би төсөв дээр нэг бас нэг та бүгдэд нэг зүйлийг юу яаж хэлье. Яах вэ манай нийт 1,2 сая хүүхэд байгаа юм. 1,2 сая хүүхдэд энэ мөнгийг хуваахаар нэг хүүхдэд 6 мянга орчим төгрөг ноогдож байгаа. Нийт хүүхдийн 1/3-д нь жишээлбэл ийм халамж

хамгаалал шаардлагатай гэх юм бол эрсдэлд байгаа халамж хамгаалал шаардлагатай нэг хүүхдийн зардал 16, 7 мянган төгрөг болж байгаа. Гэтэл бид нар жишээлбэл 2020 онд ноосны урамшуулал 20 тэрбум төгрөг, арьс ширний урамшуулалд 10 тэрбум төгрөг бид нарт төсөвлөж байгаа. Тэгэхээр нийт хүүхдийн хамгаалалд бид нарын төсөв ийм л байгаа. Сүүлийн 4 жил тасралтгүй 8 тэрбум төгрөг л байгаа. Яах вэ энүүнийг энэ хуулийг нэн яаралтай горимоор хэлэлцэх үү Улсын Их Хурал, төсвийг нэмэх үү гэдэг бол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Үүнийг манай Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд та бүхэн мэдээж өөрсдөө мэднэ. Сүүлийн хэдэн жил 4 жил тасралтгүй ямар ч юмны үнэ тогтвортой байгаагүй. Тэгэхээр түр хамгаалах байрны урсгал зардлаас авхуулаад л, хүүхдийн эсрэг гарч байгаа гэмт хэргийн тоо буухгүй байгаатай холбогдоод л, цалин урамшуулалтай холбогдоод л энэ зардлууд ерөнхийдөө бол нэмэгдэж орж ирж байгаа юм.

Дээрээс нь нэмээд бид нар нэг кэйс үүсгэхээд хүүхдийн асуудлын эхнээс нь эцэс болтол ямар байгаа юм уг нь бол. Тэгэхээр энэтэй холбоотойгоор нэг кэйс үүсгээд хуульч хүртэл өмгөөлөгч хүртэл хөлсөлж авч өгдөг. Нэг хүүхэдтэй энэ кэйс дээр ажиллахаар. Тэгэхээр яагаад гэвэл уг нь бол эцэг эх нь бусад тохиолдолд бол эцэг эх нь асран хамгаалагчийн хувьд хүүхэдтэйгээ хамт явдаг, энэ хуульч өмгөөлөгчөөр хангадаг байсан бол ихэнх олон тохиолдолд эцэг эх чинь өөрснөө хүүхдийнхээ эсрэг гэмт хэрэг үйлдчихээд байгаа учраас төр өөрөө энийг хамгаалалттай авч, төр өөрөө энэ мөнгийг гаргахаас өөр аргагүй нөхцөл байдал бас үүсчхээд байгаа. Тийм учраас бид нар энэ төсвийг ингэж юу яаж нэмж тооцож өгсөн байгаа шүү. Хэн Өлзийхутаг дарга 3 номер дээр нэмэлт мэдээлэл өгөх үү.

П.Анужин: 3 номерын микрофонд ГБХЗХГ-ын үүргийг түр

орлон гүйцэтгэгч тийм ээ, 3 номерын микрофонд хариулт өгье.

Н.Өлзийхутаг: Өдрийн мэнд хүргэе. Батлут гишүүний асуултад хариулъя. Ер нь бол бид нар хүүхэд хамгааллын хүүхдийн хөгжил хамгааллын зардлаас тодорхой хувийг бол бас энэ урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилдаа бол зарцуулж байгаа. Би бас энд 23 оныхоо төсвийн талаар бас товчхон мэдээлэл өгье. Энэ жил бол бид нар орон нутагтаа 75,4 хувийг бол орон нутагт төсвийнхөө хувийг бол тавьж өгсөн байгаа. Тэгээд урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ажил маань иргэдэд юу хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр мөн хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг бол сум аймгууд бол бүгд хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээтэй болсон. Энэ нь бол 330 сумдаа бол бас хүрч очиж хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр 2022 оноос эхэлж бид ажиллаж байна.

Нийслэлийн 9 дүүрэг дээр бол тусгай тоноглогдсон автобусаар хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг бол үзүүлж байгаа. Энэ бол бас ялангуяа эрсдэлтэй орчныг илрүүлэх, мөн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх мөн энэ илэрсэн зөрчил дутагдлыг бол арилгуулах чиглэлээр бол бид нар явуулын үйлчилгээгээ бол ажиллуулж байгаа юм. Тэгэхээр урьдчилан сэргийлэх ажлын зардал маань бол энэ жил зөвхөн 23 хувь байгаа. Тэгэхээр цаашидаа бол бид нар бас урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлыг бас нэмэгдүүлэх нь шаардлагатай байгаа юм гэж ингэж бол харж байгаа. Олон нийтэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг бол бид нар ЦЕГ, мөн ОБЕГ гээд холбогдох агентлагуудтайгаа бусад салбар дундын байгууллагуудтайгаа хамтарч бол олон ажлуудыг бол зохион байгуулж байгаа. Жишээлбэл цагдаагийн байгууллагатай хамтарсан Анзаар гээд арга хэмжээ энэ жил мансууруулах бодис, эм, сэтгэцэд нөлөөлөх бодисоос урьдчилан сэргийлэх

чиглэлээр Анзаар арга хэмжээ та бүхэн анзаарч байгаа бол бүх аймгуудад бид нар ЦЕГ-тай хамтраад ийм том арга хэмжээг бол зохион байгуулаад явж байгаа. Одоо баруун бүсэд энэ ажил зохион байгуулагдаад явж байна.

Мөн Баярсайхан гишүүний санаачилсан энэ Хүүхэд эрхэм хэрэглэгч аяныг бол тодорхой хэмжээнд бол явуулж байна. Найз байя гээд аян саяхан хэрэгжсэн, үргэлжлээд Чи ганцаараа биш гээд ингээд бид нар бол урьдчилан сэргийлэх чиглэлээр томоохон ийм үйл ажиллагаануудыг бол бусад байгууллагатай хамтарч болон агентлаг орон нутгийнхаа байгууллагуудын дэмжлэгтэй хамтарсан ийм ажлуудыг бол зохион байгуулж хийж байгаа.

П.Анужин: ЗГ-ын өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж Байнгын хорооны гишүүд асуулт асууж дууслаа. Тодруулах юм уу, цахимтай холбогдуулаад асуулт хангалтгүй байна гэж үзсэн учраас 1 номерын микрофон Баярмаа дарга асуултыг гүйцээж тодорхой хариулъя.

Н.Баярмаа: Цахим орчны хүүхэд хамгааллын асуудал дээр 2017 оноос эхлээд НҮБ-ын хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр ХХЗХ, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, ЦЕГ, манай яам удирдаад Хүүхэд хамгааллын цахим орчны хүүхэд хамгааллын ажлын хэсэг ажиллаж, олон улсын V protect гэсэн энэ загварыг бас хэрэгжүүлсэн. ХХЗХ дээр ekids.mn гэсэн ийм веб сайт ажилладаг. Энэ дээрээ тулгуурлаад бид нар бас хүүхдийг цахим орчны хүчирхийлэлд оруулах, бэлгийн хүчирхийлэлд уруу татах энэ мэдээллүүдийг устгадаг, black list систем ажиллаж байгаа. Тэгээд эцэг эх, олон нийтэд чиглэсэн гарын авлага, цахим орчны зохистой хэрэглээний зөвлөмж гээд 135 видео шторк, 275 постер, 251 нийтлэл бол энэ ekids гэсэн системээр явж байгаа.

Энэ асуудлаа бид нар бас нөгөө илүү хууль, эрх зүйн зохицуулалттай болох хүрээнд Хүүхэд хамгааллын хуулийн шинэчилсэн найруулга дээр цахим орчны хүүхэд хамгаалал гэсэн энэ орчны энэ заалтуудыг тодорхой болгож оруулсан. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид, цахим орчны контентын бүтээгчид, цахим орчны чиглэлээр ажиллаж байгаа байгууллагуудтай хамтарч Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн дэргэд Цахим орчны хүүхэд хамгааллын дэд зөвлөл ажиллахаар, дээрээс нь нэмээд цахим орчин дахь хүүхдийн эрхийг хамгаалах журмыг Цахим орчны сайд болон Хүүхдийн сайд, Хууль зүйн сайд хамтарч батлахаар, үйлчилгээ үзүүлэх энэ мэдээллийг эцэг эхчүүдээс нь хүүхдээ сөрөг контентыг яаж үзүүлэхгүй байх вэ, эцэг эхийн үүрэг хариуцлагыг бас тодорхой болгож орсон. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч контент бүтээгчдийн үүрэг хариуцлагыг бас тодорхой болгож оруулж ирээд, салбар дундын зохицуулалттай, журамтай, дэд зөвлөлтэй ажиллах байх энэ зохицуулалтыг бас энэ хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд оруулсан байгаа.

П.Анужин: Дамбын Батлут гишүүн, 3 дахь асуултдаа, та нар асуултаа бичиж аваад хариулмаар байна. Нөхцөл байдлын судалгаа гээд асуусан. 1 номерын микрофон, Булгантуяа сайд энэ мэргэжилтнүүд чинь асуултаа ойлгохгүй байгаа юм уу? Асуултдаа хариулж мэдэхгүй байгаа юм уу? Мэддэг хүн нь хариулт өгмөөр байна. Дамбын Батлут гишүүн өөрөө тодруулга хийе. Та нар маш хариуцлагагүй хандаад байна.

Д.Батлут: Эсвэл мэдэхгүй байгаа юм уу, эсвэл үл тоогоод байгаа юм уу. Асуулт асууж байвал юу бичиж авчхаад хариулчхаж баймаар байгаа юм 1.

2 дугаарт нь тэгээд нэг жижүүр үгээр битгий ингээд торгоогоод байгаа ч. Наад нэг хугацаа чинь явсаар байгаа

бүрэн хариулт авч чадахгүй дуусчих юм. Үгүй ээ цахим орчинд контент бүтээж байгаа, тэгвэл контент Монголчууд ч юм уу энэ Монголын контент бүтээж байгаа хүмүүстээ бид нар яах вэ ингээд нэг асуудлаа шийдээд явчхаж болох нь гэж ойлголоо. Үгүй ээ цаанаас нь зориудаар, өөр арга хэлбэрээр орж ирж байгаа гар утсан дээр орж ирж байгаа мэдээ цахим мэдээллүүдийг бид яах юм, яаж хянах юм бэ? Зүгээр яах вэ нэлээн л том түвшинд яригдах байх л даа. Тэгэхдээ энэ хуулийн төсөл дээр бид нар хүүхэд хамгааллын л асуудал ярьж байгаа бол бүх түвшний асуудлуудыг гаргаж өгч тусгаж болгож явах ёстой байхгүй юу. Тэрнээс биш зүгээр нэг өнөөдөр нэг өөрсдийнхөө хэмжээнд сэтгээд, ийм контент үйлдвэрлэгчдийг ингээд нэг журам гаргаад ингээд зогсоочихно ч гэдэг юм уу, аав ээжийн хараа хяналт дотор тэр.../минут дуусав/

П.Анужин: Дамбын Батлут гишүүнд нэмэлт нэг минут өгье.

Д.Батлут: Аав ээж нь тэр хараа хяналтаа сайжруулаад цахим мэдээллийг нь хянана ч гэдэг юм уу, тэрэн шиг үлгэр байхгүй шүү дээ нөхдөө. 4G сүлжээн хаа сайгүй орчихсон, ухаалаг гар утас хүүхдүүд бүгд хэрэглэж байгаа, ямар ч мэдээллийг яаж ч олж авах боломжтой. Магадгүй бид нараас илүү тэр цахимд ажиллаж байгаа тэд нар чинь. Тэгэхээр бид нар энэ цахимыг хэрхэн аюулгүй болгох вэ, хүүхдэд тэр буруу нөлөөлөл үзүүлэхгүйгээр тэр контентуудыг байлгахгүй оруулахгүй байх вэ гэдэг тал дээр бид нар илүү өөр юм ярих ёстой л доо. Та бүхний ярьж байгаа бол лав хариулт биш гэж хараад байгаа юм.

3 дахь асуулт нь хариулт нь 358 хүүхэд хүчирхийлэлд автсан байна. Ахиад тийм нөхцөл байдалд орох эрсдэлтэй газрууд байгаа юу, судалгаа хийгдсэн зүйл байдаг юм уу л гэсэн шүү дээ. Энэ дээр бид нар хэрхэн ажиллах юм бэ? Зүгээр болсных нь дараа бид нар ингэчихлээ гээд байх биш, илүү болохоос

нь өмнө урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх ёстой гэж байгаа.

П.Анужин: Харилцаа холбооны зохицуулах хороо, Цахим хөгжлийн яамныхан хүрч ирсэн байгаа шүү дээ энэ ажлын хэсэгт нэр нь байна. Та нар яагаад урагшаа микрофонд гараад өөрсөдтэй чинь холбоотой асуулт асуугаад байхад хариулахгүй суугаад байгаа юм. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас Оюун-Эрдэнэ байна уу? Хариултаа өгөөч. Харилцаа холбооны зохицуулах хороо Батболд. 3 номерын микрофонд суугаад энэ гишүүдийн асуултад тодорхой хариулт өгье. 4 номерын микрофоныг нээе. Тодорхой хариулт өгье. 4 ассан, 4 дээрээ.

Т.Батболд: ХХЗХ-ноос хариулъя. Батлут гишүүний хариултад. Цахим орчинд хүүхдийн эрх хамгаалах тогтолцоог Хүүхэд хамгааллын хуулийн шинэчилсэн найруулгын 3.4 дүгээр зүйлээр оруулж ирсэн байгаа. Энэ дээр хамгийн гол асуудал маань Хүүхдийн үндэсний зөвлөлийн дэргэд цахим орчин болон хэвлэл мэдээллийн өргөн нэвтрүүлгийн орчинд Хүүхэд хамгаалах дэд ажлын хэсгийг байгуулахаар оруулсан. Дэд ажлын хэсгийн гол оруулж байгаа шалтгаан нь болохоор зэрэг тухайн контентыг хүүхдэд хорттой юу гэдгийг тодорхойлох нь хамгийн чухал байдаг. Тэгэхээр энэ дэд зөвлөлийн ажил дэд зөвлөл дээрээс ажлын алба нь тодорхойлоод, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны сайд, Хууль зүйн сайдын хамтран баталсан батлах Цахим орчны хүүхэд хамгааллын журмаар бид хэд нөгөө олон улсын платформууддаа тодорхой үүргийг хүлээлгээд, тэр процессын дагуу цаашаа тухайн платформуудтай хамтарч ажиллаж, яаралтайгаар хүүхдэд хорттой контентыг устгуулах арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа.

Ер нь бол 100 хувь шууд гар утсан дээр, платформ дээр, аппликэйшин дээр ирж байгаа хүүхэд хүүхдэд хорттой

контентыг устгах бол технологийн бол боломж байхгүй. Тэгэхээр бид хэд олон улсын платформуудтай хамтарч л ажиллана, өөр сонголт байхгүй гэсэн үг.

П.Анужин: Булгантуяа сайд нэмэлт, нэмж хариултыг гүйцээж хариулъя.

Х.Булгантуяа: Саяынх дээр нэмж тодруулж хэлэхэд ер нь фэйсбүүкийн Монгол дахь салбарыг бий болгох, дээрээс нь би search дээр жишигээр хүүхдийн эсрэг ч байдаг юм уу, хүний наймаатай холбоотой ямар нэгэн үг үсэг бичихэд шууд тэр хаягийг нь юунд авдаг, хяналтад авдаг, тийм ямар нэгэн контент түгээж байгааг нь хянадаг барьдаг тийм зүйлүүд Монголд салбар байхгүй, дээрээс нь нэмээд Монгол хэл дээр search хийхэд тэрнийг нь хурдан илрүүлж чадахгүй энэ тэр асуудлууд бас байдаг гэдгийг бас анхаарах хэрэгтэй байгаа. Үүнийг манай Цахим хөгжил, харилцаа холбооны яам маань бас цаашаагаа уламжилж байгаа байх.

Бэлгийн хүчирхийлэлд өртөхгүй байх нөхцөл бүрдсэн үү гэж байна. Энэ бол их хэцүү. Ер нь бол энэ ядуурал, ажилгүйдэл, архидалт, 78 хувь нь гэр бүлдээ үйлдэгдэж байна гэдэг чинь хамгийн аюулгүй байх ёстой, хүүхдийн өсөж төрсөн гэр бүл дотор хүүхэд 10 хүүхдийн бараг 8 нь хүчирхийлэлд өртөж байна гэдэг чинь энэ асуудал бол ямар өрх болгонд нийгмийн ажилтан ажиллуулалтай нь биш үнэхээр амаргүй байна. Үүнтэй холбоотойгоор сая Энхбаяр сайд ХЗДХЯ-наас Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, ялангуяа хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг хуулийг чангатгах, дээрээс нь нэмээд үйлдсэн иргэдийг ялангуяа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүмүүсийг энэ жагсаалт гаргадаг, жагсаалтыг эсхүл ил тод, эсхүл хаалттай байдлаар тухайн аймаг орон нутгийн цагдаагийн байгууллага, хамтарсан багийнхан мэддэг ч байдаг юм уу ийм байдлаар

зохицуулалтыг хийхээр бас өргөн барьж байгаа.

Ер нь бараг л сүүлдээ эцэг эхчүүд чинь хүүхдүүддээ бараг л чин суулгаж хамгаалъя гэх нь л холгүй юм ярьж байна шүү дээ. Гэтэл эсрэгээрээ энэ хэрэг үйлдсэн хүмүүсээс тэгвэл хяналтдаа аваач. Тэгвэл бидний хүүхдүүд эцэг эхчүүд ч гэсэндээ амгалан тайван байх ийм нөхцөл бүрдэж байна гэж энэ хүрээнд Эрүүгийн хуулийг ХЗДХЯ-наас боловсруулаад бас өргөн бариад байгаа. Хамгийн чухал асуудал нь энэ хуулийн санкцыг чангатгах. Тэгээд удаа дараа гэмт хэрэг үйлдсэн энэ хүмүүсийг хувьд өршөөл энд байдаг юм уу, түрүүлж хугацаанаас нь өмнө бол түрүүлж сулладаггүй байх, суллалаа гэхэд, нийгмийн дунд гарлаа гэхэд хяналтад байдаг байх энэ тогтолцоог давхар бас бий болгох ёстой.

Дээрээс нь энэ нийгмийн сүлжээгээр бай, бусад байдлаараа ер нь энэ мэдээллийн сурталчилгааны ажлыг энэ нийгмийн энэ бухимдал сэтгэл зүйн энэ тавгүй байдал дээр бид нар өөрснөө бас ажиллахгүй бол бас их амаргүй байна. Тэгэхээр үүн дээр бас бид нар ирэх жил нэлээдгүй том ажил хийхээр бас төлөвлөж байна.

П.Анужин: ЗГ-аас өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд асуулт асууж дууслаа. Булгантуяа сайд танд анхааруулахад энэ яамны мэргэжилтнүүдийн асуудал бол мэдээж ганцхан таны асуудал биш. Тэгэхдээ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам харьцангуй боловсон хүчин, хүний нөөц тогтвортой гэж хэлэгддэг. Гэхдээ өнөөдрийн энэ асуултад хариулж байгаа байдал, эрсдэлд орох магадлалтай хүүхдүүдийн тоо баримжаа гэж байдаг уу гэдэгт хариулж чадахгүй, 3 удаа тодруулга аваад хэн нь ч хариулдаггүй ийм яам ер нь байх хэрэгтэй байна уу?

Бид нар яг хэнтэй яриад, ямар хариуцлага, ямар хуулийг энд яриад сууж байна вэ? Хэрвээ та энэ мэргэжилтнүүдээ чадавхжуулж орж ирэхгүй бол Улсын Их Хурал дээр энэ хууль бол явах боломжгүй харагдаж байна шүү дээ. Та нар хуулийн төслөө тайлбарлаж чадахгүй байна, хууль руугаа ороогүй байна, ерөөсөө та нар мэдэхгүй байна, та нар ажиллаагүй байна. Хэн нэгнээр зүгээр хуульчдаар бичүүлээд оруулж ирсэн ийм л дүр зураг харагдаж байна. Та нар ерөөсөө энэ хуулийнхаа гүн рүү, концепт руу ороогүй байна. Тэгээд ийм тайлбартайгаар энэ Улсын Их Хурал цаашаа явах уу, бид нар өнөөдөр энэ хуулийг хэлэлцэх юм уу үгүй юм уу гэдгийг шийдвэрлэх ийм чухал хуралдаан болж байхад ийм хариулттай одоо бид нар яаж санал өгөх вэ? Та энэ тал дээрээ анхаараач. Үнэхээр хүний нөөц бол хангалтгүй байна. Баярмаа дарга та ингэж сандраад хариултаа өгч чадахгүй байгаа юм уу, нэг бол та ажлаа ерөөсөө мэдэхгүй байгаа юм уу? Таны өмнөөс надад хариулж мэдэх зүйл алга.

Дээрээс нь энэ ард түмний төлөөлөл болсон энэ ялангуяа энэ засаг захиргааны нэгжийг маш тодорхой нарийн мэдэж байгаа энэ гишүүдийн асуултыг та нар тэмдэглэж авч, хүндэтгэлтэй хандаач. Хэт дахиулж асуултаа асуусан ийм л хуралдаан өнөөдөр боллоо. Булгантуяа сайдаа хүний нөөцдөө анхаараач үнэхээрийн. Энэ яам бол болж бүтэхээ больсон юм байна. Тийм, бүтэц хэв хэвээрээ. Баярмаа дарга та бол энэ асуултыг түгдрэлгүй ярьж байх хүн шүү дээ. Тэгтэл арай дэндүү байна. Агентлагийн дарга нар, тэр Цахим хөгжлийн яам яагаад та нартай холбоотой асуулт асуугаад байхад гарч ирээд хариулахгүй ийм хөшүүн хойрго пээдгэр байгаа юм бэ? Ажлаа хийх хэрэгтэй шүү дээ. Яаж та нар ингэж хариулж байхад Улсын Их Хурал дээр энэ хууль хэлэлцэгдэх юм.

Гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Уг хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж уг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Балжиннямын Баярсайхан гишүүнээр уг хэлэх гишүүдийн нэрийг тасалж байна. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна, уг хэлнэ. Уучлаарай уг хэлнэ шүү.

М.Оюунчимэг: Угаасаа ингэж хугацаа алдаж орж ирж байгаа, мэдээж бид нар энэ хэлэлцэх эсэх дээр хэлэлцээд явах нь зөв. Тэгээд 100 хувь дэмжигч байгаа. Тэгээд сая бас хэлээд байна л даа. Би сая тэр Цахим бодлогын сайд нь онлайн сүлжээгээр ингэж хамгаалах бололцоотой гээд л бичээд байдаг. Энд асуулт асууж байхад тэр нь өөрсдөд нь хамаагүй юм шиг сууж байж болохгүй шүү. Би бүүр тэр Батболд даргад хэлчхээд сая хариулж байгааг нь харахад. Баярмаа даргыг бид нар загнаад яах вэ, ганц юм хийдэг хүн л дээ Баярмаа дарга бол. Тэгэхдээ энэ хүнд хүний нөөц ч алга, хөрөнгө мөнгөний мэдэл ч байхгүй юм байна лээ. Тэгэхээр энэ хүнийг ажлыг нь үнэхээр сайн хийлгэе гэвэл тэр юмыг нь салбарын сайд шийдэж өгөх хэрэгтэй. Хүний нөөцтэй нь.

Яагаад гэвэл би бас 2017 онд Нямбаатар сайд бид нар бүүр энэ Сонгинохайрханаас өгсүүлээд 9 дүүрэгт энэ хүмүүстэй цуг, хоргодох байрнаас өгсүүлээд л хүүхэд хамгааллын бүх объект дээр явж байсан. Үнэндээ хүний нөөц байхгүй. Би хэлээд байна шүү дээ ЧД-т гэхэд 20 мянган өрхөд нэгхэн нийгмийн ажил хүүхдийн эрхийн байцаагч гээд байгаад байна. Тэгэхээр хүн амын бүтэцтэй, хүн ам зүйтэй нь уялдаж хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг 1 дүгээрт хийх нь чухал байна сайдаа. Та энэ дээр бас илүү анхаараад, энэ хүмүүстэй ажиллах бололцоо өгөөд ингээд явахгүй бол ярих гээд ярьж чадахгүй байгаа байхгүй юу. Яагаад гэвэл ямар худлаа хэлэлтэй нь биш эсвэл бодит байдлыг хэллээ гээд очоод загнуулна ч гэж аягүй л айж

байгаа шүү дээ эд нар чинь. Яг үнэндээ хүний нөөц үнэхээр тааруу байгаа.

Тэгэхээр бид нар төсөв энэ 8 тэрбум гээд л байна, 8 тэрбум хангалттай биш байхгүй юу хүүхэд хамгааллын. НҮБ-ээс хийсэн НҮБ-ын Хүн амын сангийн судалгаагаар хамгийн багадаа гэхэд 11 тэрбум төгрөг зөвхөн хүүхэд хамгаалалд Монгол Улсад шаардлагатай гээд тооцоо гаргачихсан л даа. Тэгэхдээ энэ мөнгө манай гишүүд хэлээд байгаа тэр хүүхэд хамгаалалдаа явахгүй байгаад байгаа байхгүй юу. Өөр юманд зарцуулагдаад ингээд яваад байна шүү дээ. Тэгэхээр л бид нар хүүхэд хамгаалал гэж яриад байдаг, тэгээд энэ нэг юу кэйс гарахаар л ярьдаг, тэгээд хууль чангатгадаг, хэрэгждэггүй. Дараа нь дахиад л нэг юм гарна. Энийгээ яриад сууж байхгүй байх нь өөрөө чухал байна л даа. Тэгээд энд хэлэлцэх эсэх нь дэмжигдээд мэдээж явж таараа.

Гишүүд аягүй чухал санал бас хэлээд байна шүү дээ. Эд нар чинь бид нар чинь анхан шатанд иргэд олон нийттэйгээ энэ ажлыг хийж байгаа тэр анхан шатанд халуун цэг дээр ажилладаг хүмүүстэйгээ уулзаад энийг ингэж илүү сайжруулбал үр дүн гарах юм гээд санал хэлээд байна. Тэгэхээр та бүхэн маань зүгээр бид нарын асуултад хариулт өгөх нь чухал биш шүү дээ. Хамтраад болоод байгаа юмыг тодорхой шинжлэх ухааны үндэстэй, энэнээс болоод ийм, ийм асуудал үүсээд байгаа, эд нарыг нь шийдчихвэл бас энэ хүүхэд хамгааллын асуудал өөр түвшинд гарна гэдгийг л бид хамтдаа одоо хийх нь чухал байна шүү дээ. Тэгээд энэ өөрөө төсөв хэлэлцэж байгаа энэ үед, төрийн мөнгөний бодлого хэлэлцэгдэж байгаа энэ үед давхцаж орж ирж байгаагаараа өөрөө бас онцлогтой байгаад байна. Тэгэхээр түрүүн тэр камержуулалтын асуудлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс гээд л хэлж байна. Бас энийг заагаад өгчихгүй бол тэнд энэ яг тусгагдахгүй.

Харин улсын төсвийн дараа, нийслэлийн төсөв, дүүргийн төсөв, орон нутгийн төсөв хэлэлцэхэд та нар яг хүүхэд хамгаалалтай холбоотой ийм объектод энэ хэдэн газрыг заавал камержуулах тэр төсвийг тусгана шүү гээд яг тодорхой зааж өгөхгүй бол энэ хэрэгжихгүй. Дунд нь хаяад л өнөөдрийнх ишг энэ нь тайлбарлаж чадахгүй, асуултад хариулж чадахгүй ингээд л байж байна шүү дээ. Тэгэхээр бид юу хүсэж байна, үнэхээр хүүхэд хамгаалал Монгол улсад өөр түвшинд гараасай гэж бүгд хүсээд байна. Бид санхүүжилтийг шийдээд л, хуулийг чангатгаад л байгаа хэр нь бодит амьдрал дээр буурахгүй харин ч бүүр нэмэгдээд байж байна шүү дээ. 78 хувь дуудлага нь хүртэл 51 хувиар өсчихсөн, гэр бүлийн хүчирхийллийн, гэр бүлийн хүрээнд өртөх нь 78 хувьтай байна гэнэ. Энэ ажилгүйдэл, ядуурлаас үүдэлтэй гэж бид нар яриад сууж байх биш Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам чинь өөрөө ажилгүйдэл, ядуурлыг давхар бас шийдэхэд чухал үүрэг гүйцэтгэх яам. Тэгээд энийг, мэдээж ганц энэ яамны ажил биш бүгд хамтын ажил. Тэгэхээр яг энэ үүрэг хариуцлагуудыг нь аваад явчих нь чухал байгаа.

Сая тэр Гэр бүлийн тухай хууль ХЗДХЯ-наас оруулж ирж байгаа хууль дээр, Эрүүгийн хуульд орж байгаа нэмэлт, өөрчлөлт дээр эцэг эхийн асуудлыг үүрэг хариуцлагыг маш чангатгах гэж байгаа юм байна лээ. Энэ бол маш чухал. Ялангуяа тэр Энхбаяр сайдын бид нарт тайлбарласнаас аваад үзэхэд ямар ч байсан яг гэр бүлийн маргааныг шүүдэг тусгай шүүхтэй болох юм байна. Энэ дээр бас эцэг эхийн үүрэг алдсан бол яах вэ? Ихэнх хүчирхийлэл хойд эцэг эхтэй юун дээр гарч байна шүү дээ. Тэгэхээр энэ бас нөгөө гэр бүл салалт энэ тэр гээд нийгмийн энэ асуудлыг бид нар хаана хаанаа яг тодорхой шийдэж, тэрийг нь хуулиас гадна санхүүжилт, хүний нөөц гээд цогцоор шийдэхгүй бол энэ асуудал явахгүй. Тэгэхээр бүгдээрээ энэ ёстой хэлэлцээд, нөгөө бүгдээрээ хэлэлцвэл

буруугүй гэдэг шүү дээ. Тэгэхээр яамныхан энэ бүх салбарын сууж байгаа хүмүүс маань гишүүдээс гарч байгаа саналыг бичиж аваад, тэгээд энийгээ хэлэлцүүлэг явцад энийг нь тусгамаар байна, энийг нь тусгаад, ийм санхүүжилт нь хэрэгтэй гээд ингэж байж л үр дүн гарна шүү дээ. Тэгээд энэ дээр илүү онцгой анхаарч ажиллахыг би бас салбарынханд, энэ хамтарч сууж байгаа бүх яамдын уялдаа холбоо дээр нь онцолж хэлье гэж бодож байна. Баярлалаа.

П.Анужин: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэллээ. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн үг хэлнэ.

С.Ганбаатар: Энэ нийгэмд хирдхийлгэсэн цочоосон айхтар юм болсон. Тэгээд хэдүүлээ бас унтчихгүй ишг энийгээ ингээд байнга үзээд, энэ дээр үр дүн гаргахын төлөө ажиллах ёстой. Дараагийн нэг бас нэг цочролыг хүлээгээд л бас хаячих гээд байдаг шүү дээ манайхан чинь. Энэ хуулийн төслийг уншлаа, нэлээн гаднаас л хуулсан байна даа. Тэгээд энэ нь шүүмжлэх гэхээсээ илүү энийг засаж залруулах талаас нь би нэг хэдэн санаа хэлье. Ер нь манай Монголчууд бол хүүхдээ хамгаалж ирсэн түүхэн уламжлалт зан заншил ямар байсан бэ гэдгийг энд их түлхүү оруулмаар байна. Үзэл баримтлалд бол яг Монголын ард түмний уламжлал, зан заншлын талаар ер нь юм алга. Бид чинь хүүхдээс үгүй ээ чи юунаас айж байна гэвэл Шрек гэдэг болчихоод байгаа шүү дээ. Тэгээд бид чинь хөөрхөн үндэсний бас атгаалжин хар мангастай улсууд шүү дээ, уг нь ард түмэн чинь 15 толгойтой.

Тэгэхээр тэр нэг юм хуулахаасаа илүү төсөлд Монгол хэл, соёл, ёс заншлын тухай их оруулмаар байна. Нарийн яривал тэр яг үнэн. 358 хүүхэд хүчирхийлэлд өртсөн гэж байна, ихэнх нь л эрэгтэйчүүд л хүчирхийлсэн болж таараад байгаа үнэн. Нарийн яривал энэ эрэгтэйчүүдийг бас л Монгол ээжүүд л

хүмүүжүүлсэн байгаа юм шүү дээ. Том зургаараа харъя, том зургаараа. Тэгэхээр энэ соён гэгээрэл, хүмүүжлийн, ёс заншлын юмнууд энд ерөөсөө ороогүй байна. Энийгээ оруулах тал дээр ажлын хэсэг дээрээ анхаарах байх гэж бодож байна.

2 дугаарт үнэн. Урд хөл бүдэрвэл хойд хөлийг ташуурдана гэдэг шиг ядуурал, ажилгүйдэл, архидалт гаарсны хортой үр жимсийг л нийгмийн хамгааллынхан тайрах гээд л оролдож байгаа хэлбэр. Нарийн яривал Оюу толгой, нүүрсний хулгай, Эрдэнэтийн хулгайнууд нь газар авчихсан учраас авлигал ихэсчихсэн учраас л ийм юм болж байгаа. Зүгээр энийг эс өгүүлээд, 2-т нь миний хэлэх гэж байгаа зүйл гэвэл хууль дээр нэг хэд хэдэн санааг анхаараач. 1.12 дээр Кэйс менежмент хуудас 3-д үзээрэй. 1 дүгээр бүлгийн тэр хуудас 32-т 4.10 дээр бас кэйс менежмент гэж орж ирсэн байна. Энийг аль болохоор Монгол утгаар, Монгол ёс заншилтай холбож яривал их буян болно гэж. Төслийн 1 дүгээр дэд бүлэг дээр хүүхдийн эрхийг хууль зүйн хороо хамтарсан баг гээд нэг юм бичсэн байгаа юм. 2.11 дээр хууль зүйн хороо, нийслэл, сумдад огт байхгүй юм шигээр биччихсэн байгаа, та нар хуудас 11-ийг хар даа. Аймаг, дүүргийн Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хэрэг гээд ингээд чиг үүрэг бүхий зөвшилцөн байгуулна гээд ингээд биччихсэн байгаа. Тэгэхээр энийг та нар нэг эргэж хараач. Нийслэл сумдад байхгүй юм шиг.

Гэтэл энэ зүгээр 11 дүгээр хуудас бол ер нь найруулгын хувьд их алдаатай байна та нар нэг хараач. 2.11.5 дээр бол тэр дүүрэг, сумд байхгүй бол гээд ингээд бас тайлбарлаад явчихсан. 1 дүгээр бүлэгт ер нь бол 2.11, 2.11.5, 2.11.9 дэх хэсгийн заалтууд хоорондын уялдаа ерөөсөө огт ойлгомжгүй, муутай байна. Энийг би ажлын хэсгийнхэнтэй жич ярина. Ямар ч байсан өнөөдөр би санал дээрээ бас хэлчихье. Дараагийн нэг санал бол 1 дүгээр дэд бүлэгт байгаа Хүүхдийн

эрхийн хууль зүйн хороо хамтарсан баг гэсэн хэсэг нь төслийн хуудас 15-ыг би ярьж байна шүү. 2.15-аас 2.17 дээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуультай холбогдох уялдааг нягтлах нь зүйтэй. 2 хуульд энэ хороо хамтарсан баг гээд томъёоллоор орчхоод байгаа байхгүй юу, 2 хууль дээр явж байна шүү. Хамтарсан баг гэдэг 2 хуульд ингээд зэрэг байх нь зохимжтой юу үгүй юу гэдэг дээр ажлын хэсгийнхэн бас бодож санаа оноогоо ярина гэж би бодож байна.

Тэгээд эцсийн дүндээ энэ хууль бол тэр үнэн шүү дээ. Айл болгон камер тавилтай нь биш дээ, convention гэж байгаа юм шүү дээ. Энэ чинь урьдчилан сэргийлэх хууль шүү, яг нарийн яривал урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарах, соён гэгээрүүлэхэд онцгой анхаарах тийм үзэл баримтлал дээрээ Монгол ёс заншлаа ахиухан оруулмаар байна ерөөсөө огт хаячихсан байна гэдэг ийм байр суурийг ажилдаа тусгаж ажиллана уу. Хэлэлцэх эсэхийг нь дэмжээд явна. Чамбайхан шиг юм гаргахгүй бол зүгээр нэг гаднынхнаас нэг ийм сору past хийчихсэн хууль байх юм бол хэдэн Монгол хүүхдүүд л их зүдэрнэ дээ, ядарна даа. Жоохон Монгол амьсгаатай, Монгол уур амьсгалтай болох санааг илэрхийлье. Баярлалаа.

П.Анужин: Сайнхүүгийн Ганбаатар гишүүнд баярлалаа. Суулийн үед энэ ЗГ-аас өргөн барьж байгаа ялангуяа мэргэжлийн яамнуудаас өргөн барьж байгаа хуулиуд нь өөрөө 9 зүйл заалттай хууль орж ирлээ гэхэд 30 зарчмын зөрөөтэй санал байх шиг. Ийм хуулиуд орж ирдэг болсон. Тэгээд үзэл баримтлалыг хэлэлцэх нь зөв гээд дэмжчихдэг, дараа нь энэ бол аймшигтай ажиллагаа болдог ийм түвшинд хууль орж ирж байгаа. Үүнийг ч гэсэн бас сая Ганбаатар гишүүн бас хөндөж хэллээ. Цагаанхүүгийн Идэрбаатар, Идэрбат гишүүн үг хэлнэ.

Ц.Идэрбат: Хуулийн төслийг бас нэлээн уншсан. Шаардлага байгааг ч гэсэн ойлгож байгаа. Тэгээд миний хувьд бас нэг сая Ганбаатар гишүүн маань бараг л хэлчихлээ дээ. Монголчууд чинь их ер нь гэр бүлсэг хүмүүс. Нөгөө сиймхий ч гэсэн гэр минь, сэгсгэр ч гэсэн ээж минь гэж. Тэгээд янз янзын гэр бүлийн хүчирхийлэлд орсон хүүхдээс хайртай хүнээ зур гэхэд ээж аавыгаа зурдаг юм гэнэ лээ зайлуул. Тэгэхээр би энэ хуулийн энэ эцэг эхийн тэр үүрэг хариуцлагыг тодруулаад хариуцлага гэж ямар юм байна вэ гэж ингэж яриад байдаг чинь бид энэ хуулийг нөгөө урьдчилан сэргийлэх ийм хууль болоосой, энэ нийгмийн ажилтан гэдэг хүнийг гаргаад энэ эрсдэлтэй эцэг эхэд урьдчилж хэлж сануулж ойлгуулж, энэ нэг эцэг эх хэн хэн нь ийм хэцүү байдалд битгий ороосой, нэг Монгол гэр бүл бүтэн байгаасай л гэж ингэж л бодоод байгаа юм л даа.

Тийм учраас энэ яах вэ Гэр бүлийн хууль одоо бас боловсруулагдаж байгаа. Энэ дээр ч гэсэн бас нэг ерөнхийдөө бид бас нэг ийм үзэл баримтлалтай байхгүй бол болохгүй юм уу даа гэж бас олон зүйл дээр бас анзаарагдаад байдаг учраас би зориуд эхэлж бас тэр эцэг эхийн үүрэг роль гэдэг зүйлийг бас асуусан юм. Тэгэхээр урьдчилан сэргийлэх тал дээр бид онцгой анхаарах ёстой, хэлж сануулах ёстой гэдэг ийм талын юмыг бас 1 дүгээрт би хэлэх гээд байгаа юм. Тэгээд энэ хууль дээр ер нь тэгээд гэр бүлдээ л хүн хүмүүжих ёстой шүү дээ л гэж ингэж хэлэх гээд байгаа юм л даа.

2-т нь яах вэ энэ хуулийн төсөлтэй холбогдуулаад би чуулганы танхимд бас нэг хэлж байсан. Гэр бүлийн хүчирхийлэл ялангуяа хүүхдийн хүчирхийлэлтэй тэмцэхэд, урьдчилан сэргийлэхэд бидэнд 2 арга зам байна. Нэг нь бол энэ яг сургууль юуны нийгмийн ажилтан. Энэ нь бол баг нь тусдаа байх ёстой шүү, сум хороо гэж ингэж оруулсныг бол засах байх гэж ингэж бас бодож байна хэлэлцүүлгийн явцад. Нөгөөдөх нь бол би боловсролын

байгууллагаараа дамжаад бид хяналтаа тавих бас бүрэн бололцоотой. Би өнөөдөр бас сургуулийнхантай уулзаж ярилцаж байсан, утсаар холбогдсон. Мянгаас дээш хүүхэдтэй сургуульд нэг нийгмийн ажилтан бол нөгөө нэг дэвжээ тэмцээн нөгөө нэг цагаан шугам юу билээ тийм мэтийн юм хийхээс өөр хэтэрдэггүй юм билээ. Тэгэхээр ер нь ахлах, дунд, бага гэсэн нийгмийн ажилтныг энэ мянгаас дээш хүүхэдтэй сургуулиудад ажиллуулаад, энэ чинь хүүхдийн сэтгэхүй, нас, биеийн онцлог, физиологийн хөгжил янз янз байгаа учраас яг тэр лүү нь чиглэсэн энэ хүүхэд хамгааллын арга хэмжээнүүдийг бас хийгээд явах юм бол, тэгээд энэ баг хорооныхоо нийгмийн ажилтантай хамтраад эд нар ингээд ажиллах юм бол бид ер нь олон хүүхдийг эрсдэлээс хамгаалж чадна даа л гэж ингэж би бол боддог юм. Энэ бол Монголд яг бэлэн байгаа ийм бүтэц шүү дээ. Бид нэг их шинэ юм хийх гээд байгаа юм биш.

Дараагийн нэг зүйл бол бидэнд ердөө энэ хууль, дүрэм, журам ердөө багадаагүй яг үнэнийг хэлэхэд. Зүгээр мөрдүүлж байсан уу үгүй юү, мөрдүүлэх санхүүгийн эх үүсвэрийг нь бид нар шийдэж өгсөн үү үгүй юү гэдэг л нэг том асуудал байгаа юм. Тэгээд би энэ дээр харин энэ хуулийн 2.10 дугаар зүйл дээр энэ бүх шатын Засаг даргын чиг үүрэг гэдэг дээр орж ирсэн байна л даа. Тэгээд 1.2 дээр бол тэр санхүүжилтийг тусгах гэдгийг бол би заавал гэж оруулчихвал яасан юм, аймгийн төсвөөс энэ хэдэн хүүхдэдээ юм тавих мөнгө хангалттай гарна. Энэ нийгмийн ажилтнуудын ажиллах бололцоо бүх зүйлийг хангаад байх бололцоо гарна. Аймаг болгонд хүүхэд хамгааллын байрны асуудлыг шийдээд байх бололцоо гарна. Тэнд ажиллах тэр боловсон хүчний цалин цагааны асуудлыг, бусад ажилтны цалин урамшуулал дээр нь нэмээд ч хамаагүй өгчих бололцоо байгаа юм. Тэгэхээр энийг ингээд оруулъя. Бүх юмыг улсын төсөв рүү бас татаад байж болохгүй байх.

2-т нь тэр сумын Засаг даргын үүрэг дээр яг сум, баг дээр ажиллаж байгаа хамтарсан багийн үйл ажиллагааг тогтмол явуулахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг сумын төсөв дээрээ баталдаг болъё. Яах вэ дээ нэг хашааны нэг худгийн үнэ л хасагдана биз дээ. Тэгээд яах вэ зүгээр амьдрал дээр хараад байхад нэг ч гэсэн хүний нүдэнд харагдах юм хийж байвал гэсэн байдлаар бас хандах гээд байдаг. Тийм ч байсан. Гэхдээ одоо яг энэ асуудлуудад бид нар нэг юмыг хасаад тавьчих л мөнгө байхгүй юу. Тийм учраас энийг бүүр яг хууль дээр нь тусгаж өгөөд, сумын ИТХ төсвөө батлахдаа энэ хамтарсан багийн үйл ажиллагааг хэвийн явуулах санхүүгийн бололцоог нь бүгдийг нь шийдэж өгнө үү гээд. Тэгээд энэ чинь бол сум сумаасаа шалтгаалаад янз бүр хэлбэлзэлтэй байна л даа. Заримд нь бол багахан юм орно, заримд нь бол овоо юм орно, ялангуяа аймгийн төв энэ тэр болохоор. Тэгэхээр яг би энэ хууль дээр бол нэг үндсэндээ сум хороо гэдэг дээр баг гэж нэмье. Энэ аймгийн Засаг даргын үүрэг дээр тэр төсвөөсөө санхүүжилтийг зайлигүй нэмэх ёстой гэсэн нэг ийм юм оруулъя, сумын Засаг дарга бол хамтарсан багийн үйл ажиллагааг явуулах санхүүгийн юмыг нь шийдчихье гээд. Ингээд энэ хууль дээр байгаа энэ одоо тохиолдлууд дээр ажиллах энэ менежмент эд нар юмнуудаа хэрэгжүүлээд ингээд явчихвал бас ч гэж би бол учиртай болох болов уу л гэж ингэж бас харж байгаа юм. Тэгээд энэ хуулийг бол үзэл баримтлалын хувьд хэлэлцэх нь зүйтэй гэж ингэж үзэж байна. Баярлалаа.

П.Анужин: Яг Баярмаа даргын нөгөө хэлээд байсан бид нар бас хуульдаа шингээхийг зорьж байгаа ч гэсэн нөхцөл байдал тогтолцоо дээр бас асуудлууд байгаад байна гэдэг дээр гишүүд бас маш тодорхой саналыг хэлж байна. Та бүхэн маань бас энийг харгалзаж үзэх нь зүйтэй. Маш олон гишүүд энэ тухай саналаа илэрхийлж байгаа. Салдангийн Одонтуяа гишүүн үг хэлнэ.

С.Одонтуяа: Баярлалаа. Тэгэхээр хуулийг үзэл баримтлалынх нь хувьд дэмжиж байгаа. Ер нь бол энэ Хүүхэд хамгааллын хууль дээр бас дэвшил гарсан уу гэвэл гарсан зүйл маш их байгаа. Хамтарсан баг бол бас нэг ийм ойлголттой болчихсон. Би одоо манай хуучин дүүргээр ингээд л хороодоор явж байхаар тэр олон улсын байгууллагууд хэвлэж өгдөг юм шиг байгаа юм. Хамтарсан багийн тийм постерууд маш их байдаг. Хороогоор, орон сууц, СӨХ-өөр, Тэгээд энэ чинь хүмүүст ийм нөлөөллийн ажил бол их хийгдэж байгаа. Тэгээд ер нь бол олон улсын жишигээрээ ингээд цаашаа улам хөгжүүлээд, бүүр нутагшуулаад ингээд явуулсан нь дээр.

Сая Идэрбат гишүүн, Сандаг-Очир гишүүн байнга хэлдэг шүү дээ. Нөгөө энэ хамтарсан баг орон нутагтаа ерөөсөө төсөв нь алга гээд. Тэгээд энийг жил болгон л хэлдэг юм. Тэгээд энэ төсөв мөнгийг нь Булгантуяа дарга би маргааш чуулган дээр асууя. Яг энэндээ хэдэн төгрөг 24 онд төсөвлөхөөд байгаа юм бэ? Танай намын 20 оны мөрийн хөтөлбөрийг харахад бол жигтэйхэн л мундаг юм байдаг. Тэгээд төсөв чинь батлагдсан юм уу, энийг маргааш асууна шүү. 2 дугаарт энэ ЦЕГ нэг сүүлийн үед энэ фэйсбүүкээр нэг аян хийдэг болсон. Энэ аян маш үр дүнтэй. Ер нь бол би бол хүмүүст их баярлалаа л гэж хэлмээр байна. Үнэхээр хөөрхөн, хөөрхөн яг тэр хүүхдүүдэд нөлөөлөхөөр юм хийж байгаа, сайн зүйлүүд байна.

Нөгөө талаасаа бол хариуцлагагүйн зуд бол нүүрлэж байгаа шүү дээ. Манай БГД-т би сая иргэдтэй уулзахад энэ бүх хороон дарга нь томилогдоогүй гээд та нар бод доо. Тэгэхээр юун тэнд хүүхэд хамгаалал. Засаг дарга нь хүүхдийн өөрөө хамгаалах комиссын дарга шүү дээ. Засаг дарга 8 сар байхгүй Баянголд, юун хүүхэд хамгаалал гэх мэтчилэн ийм зүйлүүд байгаа юм. Тэгээд тэр 300 тайлан авдаг юм бол тэрийг нь Булгантуяа дарга нэг

жоохон багасгаад энэ тэр нэг ачааллыг нь бууруулчихаж болдоггүй юм уу.

Дээрээс нь энэ хүүхдийн эрхийн байцаагч гээд би өөрөө нөгөө 16 онд энэ хуулийн ажлын хэсэг яахад нь гол хуулийн шигтгээ нь энэ байсан байхгүй юу. Энд тэнд хүүхдийн эсрэг гэмт хэрэг гарлаа, шууд очлоо, шүгэл үлээлээ, нийгмийг сэрээлээ, бүх хүмүүс энэ дээр анхаараад энэ хэрэг дахиж гарахгүй болтол нь ажиллах ийм л хууль байсан юм. Тэгээд одоо тэд нарыг чинь төрийн албан хаагч болгочихсон. Үгүй ээ төрийн албан хаагч юу гэж даргынхаа эсрэг шүгэл үлээгээд л, даргаа, ЗГ-ыг шүүмжлээд сууж байх вэ дээ та нар тэрийгээ больчих л доо. Жишээлэхэд та нар хүүхдийн төлөө ажилладаг ТББ-аар энийгээ гүйцэтгүүлчих. Манай энэ Цэвээн, Жавзан энэ тэр гээд насаараа хүүхдийн байгууллагад. Тэгэхийн оронд та нар яадаг вэ нэр дэвших гэж байгаа намынхаа гишүүн ТББ-д мөнгө хуваарилаад л сууж байдаг шүү дээ. Тэгэхээр энэ төрийн бус байгууллагуудаараа гүйцэтгүүл.

ХЭҮК дээр байгаа тэр хүүхдийн асуудал хариуцсан хүнийхээ тоог нэм. Энэ чинь Монгол Улсын хүн амын тал нь хүүхэд байхад тэн дээр нэг хүн хариуцна гэж байхгүй, тэрийгээ нэм. ХЭҮК-ынхон шиг одоо ингээд л гарч ирээд л ерөөсөө хүүхдийн төлөө эрхийг нь хамгаалдаг хүн байх ёстой. Мөнгөгүй биш шүү дээ, мөнгө байна. Тэгээд би Булгантуяа сайдад хэлмээр байна. Ордонд та нар өдөр болгон сонгуулийн ажлын янз бүрийн хурал цуглаан хийдэг, энийгээ болих хэрэгтэй. Хэчнээн 100 сая, гарах болгонд нь нэг тортой юм өгнө. Тэрнийхээ оронд нэг ч гэсэн хамгааллын байрыг тохижуул, нэг ч гэсэн тэр хүчирхийллийн төвд хөрөнгө оруулалт хий, нэг ч гэсэн хамтарсан багт тэр мөнгийг нь өг. Тэгээд л Ордонд нэг ингээд л нэг өдөр болгон ямар ч үр дүнгүй нэг хэдэн 100 саяар юм хийдгээ болих хэрэгтэй.

Дээрээс нь энэ хохирогч хамгааллын асуудал манайд маш хүнд. Нэг ээж зодууллаа, хүүхэд нь зодууллаа, хамгаалалтын утас руу хэллээ, үгүй ээ тэгээд хаашаа очих юм бэ? Энэ ээжийг хамгаалдаг, энэ хүүхдийг олигтой хамгаалдаг юм байна уу? Тэр байр чинь хөл гишгэх газар алга. Тэгээд энэ дээрээ ажиллах хэрэгтэй, төсөв байна уу байгаа шүү дээ. Би Булгантуяа даргад хэлсэн шүү дээ. Та хамгааллын сайд энэ хулгайч нар чинь хамаг мөнгийг чинь хулгайлаад байна, бүгдээрээ энэ мөнгөнөөс нь энэ хүүхэд, эмэгтэйчүүдээ аваад өгье. Тэр маргааш та тэр төсвийг хэл, хүрэхгүй бол бид нар гараад суулт хийж чадна шүү дээ. Яагаад хүүхдүүдээсээ, ээжүүдээсээ ингээд мөнгө харамлаад байдаг юм. Ийм зүйлүүд дээр ажил, мөнгөн дээрээ ажил, төсөв мөнгөгүй бол юм явдаггүй юм.

Дээрээс нь тэр хариуцлага тооцохгүй байна гээд Баярсайхан гишүүний хэлээд байгаа үнэн тэр хариуцлагуудаа тооц. Тэгээд 1 яамны сайд чинь 3 жилд 4 солигдчихоор чинь бас яаж ч ажил нь явах хэцүү л байдаг байх л даа. Нэг жилд 4 тийм ээ энэ чинь арай ч ийм байж болохгүй. Дээрээс нь Булгантуяа сайд тэр хөтөлбөрүүдийг маш их санхүүжүүлэх хэрэгтэй. Хүүхэд хүмүүжлийн тэр Зөв монгол хүүхэд, Би эх орон 36 гээд л маш гоё хөтөлбөр бүүр бий болгоод өгсөн. Эрдэнэ сайд маш их дэмжиж байсан. Дараа нь Ариунзаяа сайд дэмжээд жоохон хийсэн, тэгээд л зогсчихсон. Одоо бид нар чинь хүүхдээ хүмүүжүүлэх, хүүхдээ төлөвшүүлэх, тэр эх оронч үзэлтэй болгох, эрүүл чийрэг бие бялдартай болгох, өрсөлдөх чадварт бол энэ зүйлд мөнгө зармаар байна.

Тэгээд Нийгмийн бодлогын байнгын хороо нэг баахан төсөв Төсвийн байнгын хороо руу оруулдаг. Манайх энийг авахгүй гээд нэг нэг рүүгээ ингэж байгаад л ингээд болиулдаг. Энэ дээр нь тэмцэх хэрэгтэй шүү дээ. Тэгээд л дээрэлхүүлээд л энэ нэг хэдэн авлигач хулгай.../минут дуусав/

П.Анужин: Салдангийн Одонтуяа гишүүн үг хэллээ. Буланы Бейсен гишүүн үг хэлнэ.

Б.Бейсен: Энэ Улсын Их Хурлаас хүүхэд хамгаалах асуудалд анхаарал хандуулж хэлэлцүүлэг хийж, хуульд өөрчлөлт оруулж шинэчлэх асуудал хийгдэж байна л даа. Харамсалтай нь Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцоо алдагдсан. Энэ хэрэгжүүлэх үүрэг бүхий албан тушаалтан нь байгууллагууд ерөөсөө хангалтгүй ажиллаж байна, ажилдаа сэтгэлгүй хандаж байна. 108-д хүүхдийн асуудлаар мэдээлэл өгөхөд, тэгээд наадхыг чинь хэн тогтоосон, хэн нотолсон юм гээд урдаас нь загнадаг. Тэрнээс цэрвээд зарим нь яадаггүй ийм асуудлууд байж байна шүү дээ. Тэгэхээр чинь ийм улсууд дээр бас хариуцлага бас тооцож өгөх хэрэгтэй байна.

Нөгөө талаар хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаатай холбоотой хүүхдийн асуудал их зөрчигдөж байна. Хохирч байгаа хүүхдүүдийн. Хавар Баян-Өлгий аймагт 3 хүүхэд аав ээж нь зэрэг нас бараад өнчирсөн тохиолдол гарсан. Энэ Хүүхэд, гэр бүлийн газар энийг анхаараад хил хяналт, цагдаа, прокурор гарахгүй байх ёстой байсан. Гэтэл энэ хэрэг хийсэн хүн нь хилээр гараад зугтсан, 3 хүүхэд хохирч үлдсэн. Хавар Өлгийн тэр талбайд тоглоом тоглож байсан хүүхдүүд бас 7, 8 хүүхэд гэмтсэн. Нэг нь нас барсан, нэг нь бүүр гадаадад эмчилсэн бас ингээд хохирсон. Мөн хил гаалийнханд цагдаа прокурорт нь хэлж байхад энийг хилээр гаргаад явуулсан, гэмт хэрэгтэн нь зугтаад явсан гадагшаа. Ингээд хүүхдүүд хохирч байгаа асуудлууд байж байна. Энэ дээр тухайн салбарын гэр бүл, хүүхдийн, хүүхэд хамгаалах байгууллага, цагдаагийн байгууллага хамтарч ажиллахгүй бол болохгүй байна. Олон байгууллагууд байж байна.

Аймгийн төвийн багууд дээр хүүхдийн байцаагч байж байна. Эрүүл мэндийн газар тэр охидын эмч, сувилагчтайгаа ажиллаж байна. Сургуулийн хичээл эрхэлсэн хүн юу хүмүүжил эрхэлсэн эрхлэгч гээд байж байна. Нийгмийн ажилтан нь, эмч нь байж байна. Энэ бүгдтэй нь хамтарч ажиллах шаардлагатай. Яах вэ төсвийг нэмж болно л доо. Энэ дээр анхаараад нэг хамтраад ажиллачихмаар байх юм. Хамгийн гол нь камержуулалтын асуудал байгаа юм. Ясли, цэцэрлэгүүд тэр гал тогооноос авхуулаад камержуулалт хийх хэрэгтэй.

Түүрүүн бас энэ Чинбүрэн гишүүн ярилаа. Хүүхдийн даатгалын асуудал байж байна. Ялангуяа ЭМД дээр. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгал энийг би 3 жил ярьж байна. Ихэнх нь Турк, Солонгос явж байна. Тухайн салбарын ЭМД-ын газартай ч юм уу, энэ даатгалын гэрээ хийх хэрэгтэй. 60-аас 100, 150 сая доллар мянган доллар гээд төлж байна. Гэтэл даатгалын гэрээ хийчихвэл зөвхөн даатгалыг нь тухайн улс өөрсдөө олж өгнө, зөвхөн даатгалаа л төлнө шүү дээ. 2 мянган ногооноос 12 мянган ногооны хавьцаа ч юм уу, тэнд эмчлүүлэх байртайгаа шийдэж байдаг. Би Эх нялхсын төвд ч ирээд хэлсэн. Энэ 2, 3 сайд солигдлоо, бүх сайдууд дээр ярьж байгаа юм. Энэ дээр нэг анхаарч ажиллаж өгөөч, энэ даатгалынхан энэ дээр нэг гэрээ хийчихвэл ард түмэнд, хүүхдүүдэд энэ их тус болох юм.

Энэ хуулийн төсөл дээр эрүүл мэндийн салбар дээр нэг ерөнхий л болсон байна. Энэ дээр анхаараад нарийвчлаад ЭМЯ-ныхантай хамтраад бас асуух асуудлууд байж байна. Эрсдэлтэй хүүхдүүдийн бүртгэл тухайн сургуулийн эрүүл мэнд эмчид нь юм уу, цэцэрлэгийн эмчид нь тахир дутуу хүүхдийн бүртгэл, өвчтэй хүүхдийн бүртгэл нь цахим бүртгэл нь байж байх ёстой. Нөгөө талаар донтолттой холбоотой хүүхдүүдийн бүртгэл нь бас байж байх

ёстой. Одоо сургуулийн хүүхэд дээр электрон тамхи гээд бүүр хэрээс хэтэрлээ. Энэ дээр нэг анхаарч хамтарч ажиллаач гэдгийг хэлмээр байна. Энэ тухайн салбар энэ сайд ер нь цагдаагийн байгууллага, боловсролын байгууллага, захиргааны байгууллагуудтай хамтрахгүй бол энэ зүгээр төсөв нэмүүлнэ ингэж тэгнэ гээд байвал бас, саяын тухайн үед Хүүхэд, гэр бүлийн газартай ажилд нь оруулаад, энэ мэргэжилтнүүдээр сайн хангах шаардлагатай байгаа юм.

П.Анужин: Цэндийн Сандаг-Очир гишүүн үг хэлнэ.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Хүүхэд хамгааллын хуулийн нэмэлт, өөрчлөлт нь хүүхдийн эрхийн зөрчлийн асуудалд яг ийм тодорхой бодит ахиц өөрчлөлт, дэвшилт гарчихна гэсэн итгэл үнэмшил бол надад бол яг төрөхгүй байна энэ удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр. Хуулийн төсөл жоохон дутуу дулимаг боловсрогдож орж ирж байгаа юм болов уу даа гэсэн дүгнэлттэй байна хувьдаа. Ер нь та бид бас ер нь өвчнийхөө оношийг зөв олж харж байгаа юм болов уу даа. Зөв оношилж чадахгүй бол зөв эмчилж чадахгүй гэж хувьдаа бодож байгаа. Тэгээд Улсын Их Хурал бол хууль, эрх зүйн орчин, төсөв санхүүтэй холбоотой асуудлыг л шийдэх, дэмжих талаас нь ажиллана. Зөвхөн хүүхдийн асуудал энэ 2 асуудлаас гадна олон зохион байгуулалтын асуудлууд бий.

Тэгэхээр бас би бол нэг сургуулийн нийгмийн ажилтан, хорооны нийгмийн ажилтан, хамтарсан багт ч асуудлын гол нь байгаа ч юм уу үгүй ч юм уу гайхаж л байна. 2000, 3000 хүүхэдтэй сургууль дээр нэг дээд сургууль төгссөн нэг охин ажил амьдралын туршилагагүй охин очоод 2000, 3000 айлын хүүхдүүдийн асуудлыг, нийгмийн асуудлыг ч гэдэг юм уу, 5000, 10000 хүн амтай хорооны айлуудын асуудлыг ч яаж шийдэх юм бол, хэчнээн ч тоог нь нэмээд энэ хэр үр дүнд

хүрэх юм бол, хэр үр дүнд хүрэх бодитой ажил юм бол гэж.

Хамгийн гол нь ерөөсөө энэ хүүхэд гэр бүлийн орчин, сургуулийн орчин 2-т л өсөж байгаа юм. Гэртээ ирээд эцэг эхчүүд сургалт хүмүүжлийн ажил хийх ёстой, сургууль дээрээ очоод багш нар нь сургалт хүмүүжлийн ажлыг л хийх ёстой. Ерөөсөө энэ боловсролын сургалтын тогтолцоонд асуудал байгаа. Хүүхэд гэдэг бол юу ч бичээгүй цагаан цаас байгаа. Тэр цагаан цаасан дээр хэрхэн яаж сургалт хүмүүжлийн ажлыг хийж өгч цэнэглэж өгөхөөс л шалтгаална. Гадаа гараад энэ нийгэм нь дандаа алаан хядаан, үзэж байгаа кино нь дандаа дарангуйлал хүчирхийлэл ийм л нийгэмд өсөж байгаа байхгүй юу. Сургалт хүмүүжлийн ажлаас нь энэ нь давчхаад байна шүү дээ. Тэгэхээр тэр хүүхдүүд тийм үзэл бодлоор төлөвшиж хөгжихгүй гээд яах юм. Тийм учраас ерөөсөө энэ гэртээ гэрийн даалгаврыг нь дааж давшгүй олон даалгавруудыг хийдэг байдлаасаа бас татгалзаж, ерөөсөө энэ хүүхдүүдийг хүн байх, эцэг эх байх, хүнийг хайрлах, найзыгаа хайрлах, аав ээжийгээ хайрлах ерөөсөө ийм л сургалт хүмүүжлийн ажлуудыг л манай энэ сургалтын тогтолцоонд ерөөсөө хаягдчихсан юм болов уу л гэж би харж байгаа юм.

Тэгээд ерөөсөө энэ хүүхэд чинь багаасаа хэн байх нь ерөөсөө энэ 3 настайдаа цаашидаа ирээдүйн хэн байх нь 95 хувь нь тэнд бойжиж байдаг гэж байгаа шүү дээ. Тэгэхээр ерөөсөө энэ чинь Боловсролын яамтай маш чухал холбоотой, сургалтын боловсролын тогтолцоо хөтөлбөртэй маш чухал холбоотой. Сургалтын хөтөлбөрт нь хүн байх сургалт хүмүүжлийн ажлууд ерөөсөө орхигдчихсон, хаягдчихсан. Тийм учраас хүнийг хайрлаж мэдэхгүй өсөөд байна. Ээж аавыгаа хайрлаж өсөхгүй байна. Эрэгтэйчүүд нь эмэгтэй хүүхдийг хайрлахгүй байна. Энэ чиглэлийн сургалт хүмүүжлийн ажлууд нь хаягдчихаад байгаа учраас тэр хүүхдүүд алаан

хядаан, хүчирхийлэл, садар самуун, тэгээд л нөгөө нэг буруу дадал хэвшил, архидалт, тамхидалт үгүй ээ ийм л юм байна шүү дээ. Гадаа гудамжинд гараад л ийм л байдлаар өсөж хүмүүжиж байна шүү дээ. Тийм учраас энэ сургалтын тогтолцоо юмнуудад нь өөрчлөлт оруулах, сургалтын хөтөлбөрт нь өөрчлөлт оруулах гэдгээс авхуулаад олон хийх ажил би хувьдаа байна л гэж харж байгаа юм, харж байгаа юм.

Үнэхээр энэ Их Хурал, ЗГ хүүхдийн төлөө гэж хүүхдээ дэмжье, хүүхдээ хайрлая, хамгаалъя гэж байгаа юм бол одоо яг энэ цаг үед 24 оны төсөв боловсрогдож байна, орж ирж байна. Та бүхэн дараа чуулган дээр ирэх жилийн төсөвт үнэхээр энэ ЗГ хүүхдийн чиглэлээр хамгаалал, хөгжлийн чиглэлээр ямар төсөв баталж өгсөн юм бэ гэдгийг нэг та бүхэн ангилаад ялгаад хөрөнгө оруулалтын чиглэлээр хэрхэн яаж оруулж ирснийг ялгаарай, би асууна үнэхээр. Үнэхээр хүүхдээ гэж бодож байгаа юм бол яг хүүхдийн асуудал яриад, хүүхэд хамгааллын байр яриад, Хүүхэд хөгжлийн төв яриад, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төв яриад ирэхээр л хүүхдээсээ төсвөө харамлачихдаг. Яг төсөв ярих үеэр л хүүхдээс төсвөө харамлачихдаг. Өнөөдөр ингээд л гоё, гоё юм ярьж л байна. Нэг кэйсийн ар дээрээс олон асуудлууд ярьж л байна. Яг бүх асуудлуудын чинь цаана төсөвтэй холбоотой байгаа. Тэгээд төсөв ярих гэхээр тийм ч зардал нэмэгдүүлнэ, ийм ч гоё сайхан зам гудамж талбай барина гээд хүүхдийг хөгжүүлэх, хүүхдийг хамгаалах, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр төсөв юм ярих гэхээр л танаад л хасчихдаг. Яг энэ байдал энэ 24 оны төсөв дээр ямаршуухан байгаа юм бол гэдгийг та бүхэн бас нэг чуулган дээр бас мэдээлэлтэй орж ирээрэй, асууя гэдгийгээ хэлье.

П.Анужин: Цэндийн Сандаг-Очир гишүүн үг хэллээ. Балжиннямын Баярсайхан гишүүн үг хэлнэ.

Б.Баярсайхан: Миний энэ хариуцлага тооц, бодлогын бодлогодоо дүгнэлт шинжилгээ хий, төсөв нь хүрч байгаа юм уу үгүй юү гэдгээ зөв тодорхойлж орж ирээч гээд ингээд асуугаад байгаа нь үнэндээ энэ хүүхдэд хуваарилагддаг цөөхөн хэдхэн төгрөгийг итгэмжгүй зарцуулж ирсэн танай яам, агентлагтай чинь холбоотой. Энэ нь аудитын дүгнэлтээр гарчихсан учраас. Тэгээд зүгээр ажлаа өгсөн нэрийдлээр идэж уусан мөнгөө төлөхгүй байгаа учраас одоо ч гэсэн энэ агентлаг дээр энэ ёс бус зүйлүүд байгаа учраас би ингээд хэлээд байгаа юм. Тэгэхээс биш хэн нэгнийг гүтгээгүй. Хэрвээ гүтгүүлж байгаа хүн байвал нэр төрөө сэргээлгэхээр бас хандаж олно шүү гэдгийг хэлчихье.

Энэ цахим орчинд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг гишүүд ярьж байна. Тун удахгүй энэ хууль бол би өөрөө энэ хуулийг санаачлан боловсруулаад тун удахгүй өргөн барих гэж байгаа. Хүүхэд хамгааллын тухай хууль дээр бол сая арваадхан зүйл, заалт орж ирсэн. Энэ нь хангалтгүй гэдэг нь ингээж харагдаж байна.

2 дугаарт ингээд хамтарсан багаа л яриад байдаг, бид нарт хүн хүч байхгүй байна, орон тоо байхгүй байна л гээд байдаг. Сая Баярмаа дарга дурдаж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-д та нарын ард маш том баг буюу Монгол Улсын нийт нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага болгон хүүхэд хамгааллын бодлоготой байхаар орж ирсэн. Ариунзаяа сайдын үед нөгөө үлгэрчилсэн загвар билүү тэр нь батлагдсан гэж байгаа. Тэгвэл танай яам, агентлаг чинь энийгээ бүх байгууллагад хүргэж ажиллах тал дээр хангалтгүй ажиллаж байгаа шүү дээ. Тэр гэр бүл дотроо хүүхдүүд гэмтэж бэртээд байна гэж байна. Ковидын дараа зөвхөн гэртээ гэмтэж бэртэж амь насаа алдаж байгаа хүүхдийн тоо 35 мянгад хүрсэн. Гэтэл энэ дээр тэр Миний гэр аюулгүй

орчин гээд бид нар хийчихсэн шүү дээ. Хийчихсэн ажлыг Ерөнхий сайдын ахалдаг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллах ёстой танай агентлагийн дарга үүрэг гүйцэтгэгчтэй явж байгаа. Энэ том үндэсний зөвлөлийг доор нь ажиллаж чадахгүй байгаа учраас энэ ажил чинь явахгүй байгаа.

Ганцхан төсөв нэмэхээр л энэ Монголын хүүхдүүд хамгаалагдаад л, сайн сайхан болчихно гэвэл үгүй. Та нар ажиллаж байгаа арга барил, явуулж байгаа бодлогодоо л дүгнэлтээ хий. Яг тийм байхад бол гишүүд хүүхдээс бол мөнгө 14 тэрбум чинь ирээдүйд хэчнээн ч тэрбум болж болох боломжтой. Энийг бол энэ араар сууж байгаа ТББ-ынхан хүлээн зөвшөөрч байгаа байх гэж бодож байна. Тэгээд энийг нь би дахин, дахин хэлээд байгаа нь хэн нэгний мууг үзэх гээд байгаа биш. Энэ том, том салбар болгонд байгаа энэ нүүрс юу байдаг юм энэ хулгайн хажуугаар очиж, очиж хүүхдийн байгууллагад хулгай нүүрлэчихсэн байна гэдгийг л жил болгон ингэж хэлж, төсөв хэлэлцэх үед, төсвийн гүйцэтгэл хэлэлцэх үед дуугарч байгаа хүн нь би. Дээрээс бүх харьяалагдах байгууллагуудын гишүүд, дарга нартай нь шалгалт шүүлгийг нь хийгээд энэ аудитын тэр дүгнэлт юмтай чинь танилччихсан хүн нь л ингээд хэлээд байгаа юм л даа.

Тэгээд л нэг ийм ээлж өнгөрөөж байгаа юм шиг Байнгын хороо, чуулган дээр орж ирээд л дүмбийж сууж байгаад л, төсөв батлуулна. Төсөв батлуулж гараад л, яг үнэндээ өнгөрсөн жилүүдэд батлагдсан тэр 8 тэрбум бол үнэндээ миний хэлж байгаа үнэн шүү. 50 хувиа та нар үнэхээр хамгаалж чадахгүй байгаа. Тэгээд 14 тэрбум болгоод юу өөрчлөгдөх юм. Ингэж хэлэхээр Баярсайхан гишүүн хүүхдийн төсвийг нэмэхгүй байна гэж хэлэх байх. Нэмэхийг хүсэж байна. Гэхдээ та нарын яг үйл ажиллагаанд итгэж өгөх нь өнөөдөр бол үнэхээр

аймшигтай санагдаж байна. Энийг бас хэлмээр байна.

Хүүхдийн хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж байгаа контентуудыг хязгаарлах талаар танай яам өөрөө гарын үсгээ зурчихсан, 5 жилийн өмнө. Хүүхэд эрхэм хэрэглэгч өдрөөр, би энэ ажлын хэсгийг мөн ахалж байсан Боловсролын яаманд байхдаа. Тэгээд одоо энд Боловсролын яамныхан байна, Цахим яамныхан байна, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам өөрсдөө байна. Яагаад Монголын телевизүүдийн холбоо, Монголын хэвлэлийн зөвлөл хүүхдийг сэрүүн байх цагаар хүмүүжил төлөвшилд нь сөрөг нөлөө үзүүлэхүйц контент гаргахгүй гээд хугацаагүй санамж бичигт гарын үсэг зурчихсан байхад төрөөс тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байгаа телевизүүдийн контентуудыг та нар яагаад өөрсдөө харж, хянахгүй байгаа юм бэ? Энэ дээр танай яамнаас хэдэн удаа бичиг явсан дэд сайдаа? Хэдэн удаа та нар Харилцаа холбооны зохицуулах хороонд хандсан бэ? Цахим хөгжлийн яам энийгээ мэдэж байгаа юу, энэ ажлаа хийгээч.

Өнөөдөр Монголын бүх телевизүүд Үндсэн хуулиас гадна бусад бүх хуулийг биелүүлнэ гээд төрөөс тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байгаа шүү дээ. Тэгээд эдний одоо явуулж байгаа энэ.../минут дуусав/

П.Анужин: ЗГ-аас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд хэлэлцэх эсэхийг Нийгмийн бодлогын байнгын хороо хэлэлцэж, гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалтын өмнө нэг зүйлийг бас зориуд хэлье гэж бодож байна. Одоо санал хураалт яваад, гишүүд хэрвээ уг хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тохиолдолд Улсын Их Хурлаар маргааш хэлэлцэгдэх байх. Энэ үед энэ мэргэжилтнүүд анхаараач, хүүхэд хамгааллын бодлого гэдэг чинь Булгантуяа сайдын бодлого,

ганцхан Булгантуяа гэдэг хүний хариуцах бодлого биш. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны асуудал бол ганцхан хүүхэд хамгааллын асуудал биш. Гэтэл өнөөдөр энэ хүн чинь л нэг асуултыг тахалж гарч байна шүү дээ. Энэ мэргэжилтнүүд чинь арга зүйн, тоо статистикийн, бодлогын чиглэл бүрийнхээ энэ бодлогоор хангаж байдаггүй юм уу энэ сайдыгаа. Ганцхан сайд нь хариулаад л, бусад нь хариулж чадах зүйл байхгүй. Баярмаа та бол маш туршилагатай мэргэжилтэн. Энэ хуулиа бол та Ба, Бэ-гүй мэдэж байгаа. Тэгэхээр одоо энэ сандрал байдаг юм уу, хэлж чадахгүй юмнуудаа хаяад, маргааши жоохон бэлтгэлтэй орж ирээч. Бүхэл бүтэн бодлогын яам ийм байдалтай Улсын Их Хуралд орж ирмээргүй байна маргааши. Энэ тал дээрээ энэ мэргэжлийн яам, Булгантуяа сайд ч гэсэн та анхаараач. Чадахгүй хүмүүс нь чаддаггүй юм бол чаддаг хүмүүсээр нь солиоч. Энийг бол бас хэлье.

Ингээд өнөөдрийн хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя гишүүдээ. Хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэж нийт хуралдаанд оролцсон гишүүдийн 66,7 хувь нь дэмжлээ. Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхийг хийлээ. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайханыг томилж байна.

16.20 цаг

Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдаан өндөрлөлөө.

Хуралдаандаа идэвхтэй оролцсон нийт гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

